



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ”
ТӨСӨЛ

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

Энэхүү Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайланг Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий мэдэгдэл

Тус тайлан нь Европын Холбоо (ЕХ)-ны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд ЕХ болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт ЕХ, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

Тайлан боловсруулсан:

Төслийн зөвлөх баг

Хянан тохиолдуулсан:

Бадарчийн Отгонцэцэг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

© 2023 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр.
Зохиогчийн бүх эрхийг хамгаалсан.

ISBN:

ISBN 978-9919-9938-4-9



9 789919 993849



ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛЛЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ

**“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ”
ТӨСӨЛ**

АГУУЛГА

Товчилсон үг	8
Ерөнхий зүйл	9

1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

10

1.1. Судалгааны үндэслэл	10
1.2. Судалгааны зорилго	11
1.3. Судалгааны хамрах хүрээ	11
1.4. Судалгааны ажлын арга зүй	11

2. ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭМЖЛЭГИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

13

2.1 Хөдөө аж ахуйн дэмжлэгийн тодорхойлолт, ангилал	14
2.2 Хөдөө аж ахуйн бодлогын зорилго, дэмжлэгийн хэлбэр	17
2.3 Хөдөө аж ахуйн дэмжлэгийн шинэчлэлийн хандлага	18

3. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

26

3.1. Мал аж ахуй	26
3.2 Газар тариалан	30

4. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ, ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛАЛ

35

4.1 Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшуулал, ангилал	35
4.2 ХХААХҮ-ийн салбарын төсвийн зардал, түүний бүтэц	37
4.3 Улсын төсвийн татаас, дэмжлэгийн зардал	39
4.4. ХАА-н дэмжлэг, урамшууллын талаарх анкет судалгаа	59
4.5. Регрессийн шинжилгээ, түүний үр дүн	66
4.6. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн тооцоо	67

5. ДҮГНЭЛТ

78

6. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

82

7. ХАВСРАЛТ

84

Хавсралт 1: Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын талаарх анкет судалгааны асуулга	84
Хавсралт 2: Регрессийн шинжилгээнд ашигласан тоон мэдээлэл	93
Хавсралт 3: Регрессийн шинжилгээ, түүний үр дүн	109

8. НОМ ЗҮЙ

114

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.	ЭЗХАХБ болон ДХБ-ын хөдөө аж ахуйн дэмжлэгийн ангиллын харьцуулалт	15
Хүснэгт 2.	Хөдөө аж ахуйн бодлогын зорилго, дэмжлэгийн хэлбэр	18
Хүснэгт 3.	Хөдөө аж ахуйн дэмжлэгийн тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөлөл	24
Хүснэгт 4.	Гол нэр төрлийн малын гаралтай бүтээгдэхүүн	27
Хүснэгт 5.	Малтай өрхийн тоо, малын тоо бүлэглэлээр	28
Хүснэгт 6.	Тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгж болон өрхийн тоо	30
Хүснэгт 7.	Газар тариалангийн үйлдвэрлэл, тариалсан талбай	30
Хүснэгт 8.	Улаан буудай, төмсний ургацын хэмжээ	31
Хүснэгт 9.	Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл ба нийт нийлүүлэлтийн харьцаа, /хувиар/	31
Хүснэгт 10.	Нийт тариалсан талбайд усалгаатай талбайн эзлэх хувь	32
Хүснэгт 11.	Газар тариалангийн салбарын харилцааг зохицуулж буй хуулиуд	33
Хүснэгт 12.	Монгол Улсад хэрэгжүүлж буй ХАА-н дэмжлэг, урамшуулал	36
Хүснэгт 13.	ХХААХҮ-ийн салбарын улсын төсвийн зарлага /тэрбум төгрөг/	37
Хүснэгт 14.	ХХААХҮ-ийн салбарын төсвийн урсгал зардлын бүтэц, /дүнд эзлэх хувиар/	38
Хүснэгт 15.	ХАА-н салбарын нийт дэмжлэг, /тэрбум төгрөг/	39
Хүснэгт 16.	ХАА-н салбарын мөнгөн дэмжлэг /тэрбум төгрөг/	40
Хүснэгт 17.	ХАА-н бүтээгдэхүүнд олгосон мөнгөн урамшууллын төсвийн зардалд эзлэх хувийн жин	41
Хүснэгт 18.	Улаан буудайн 1 тонн тутамд олгох урамшууллын тогтоосон хэмжээ	42
Хүснэгт 19.	Улаан буудайн урамшууллын мэдээ	43
Хүснэгт 20.	Ноосны урамшуулал болон бэлтгэсэн ноосны хэмжээ	47
Хүснэгт 21.	Ноосны урамшуулал, ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	50

Хүснэгт 22.	Нөөцийн мах бэлтгэлд зориулсан урамшуулал, /сая төгрөг/	52
Хүснэгт 23.	2016-20 онд Монгол Улсын махны хэрэглээ, хангамжийн түвшин	53
Хүснэгт 24.	Арьс, ширний урамшуулал, бэлтгэсэн арьс шир, зах зээлийн үнийн мэдээлэл	55
Хүснэгт 25.	Судалгаанд оролцогчдын байдал	61
Хүснэгт 26.	Судалгаанд оролцогчдын урамшуулалд хамрагдсан байдал	61
Хүснэгт 27.	Регрессийн шинжилгээний нэгтгэсэн дүн	67
Хүснэгт 28.	Ноосны зах зээлийн үнийн дэмжлэгийн тооцоо	68
Хүснэгт 29.	Ноос бэлтгэн нийлүүлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн тооцоо	70
Хүснэгт 30.	Арьс шир бэлтгэн нийлүүлэгч малчдын зах зээлийн үнийн дэмжлэг	71
Хүснэгт 31.	Арьс шир бэлтгэн нийлүүлэгч малчдад үзүүлсэн дэмжлэгийн тооцоо	72
Хүснэгт 32.	Улаан буудай тариалагчдын зах зээлийн үнийн дэмжлэг	73
Хүснэгт 33.	Улаан буудай тариалагчдад үзүүлсэн дэмжлэгийн тооцоо	75
Хүснэгт 34.	Хөдөө аж ахуйн түүх ий эд үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн тооцоо	75
Хүснэгт 35.	2010-2020 оны ноос, арьс шир бэлтгэн нийлүүлэгч, улаан буудай тариалагчдын нэрлэсэн хамгаалалт коэффициент	77
Хүснэгт 36.	Ноосны үйлдвэрлэлийн регрессийн шинжилгээний өгөгдөл мэдээллийн статистик үзүүлэлт	109
Хүснэгт 37.	Ноосны үйлдвэрлэлийн регрессийн шинжилгээний үр дүн	110
Хүснэгт 38.	Арьс ширний үйлдвэрлэлийн регрессийн шинжилгээний өгөгдөл мэдээллийн статистик үзүүлэлт	111
Хүснэгт 39.	Арьс ширний үйлдвэрлэлийн регрессийн шинжилгээний үр дүн	112
Хүснэгт 40.	Үр тарианы үйлдвэрлэлийн регрессийн шинжилгээний өгөгдөл мэдээллийн статистик үзүүлэлт	113
Хүснэгт 41.	Үр тарианы үйлдвэрлэлийн регрессийн шинжилгээний үр дүн	113

Зураг 1.	Хөдөө аж ахуйн дэмжлэгт хамаарах үйл ажиллагаа	17
Зураг 2.	ХАА-н салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь	25
Зураг 3.	ДНБ болон ХАА-н салбарын бодит өсөлтийн хандлага	26
Зураг 4.	Малын сүргийн бүтэц, хувиар	27
Зураг 5.	Хураан авсан нийт улаан буудай ургац ба урамшуулалд хамрагдсан улаан буудайн хэмжээ	44
Зураг 6.	Дотоодод үйлдвэрлэж нийлүүлсэн гурилын хангамжийн хувь олон урамшуулалд хамрагдсан улаан буудайн хэмжээ	45
Зураг 7.	Ноосны урамшуулалд хамрагдалтын хувь	48
Зураг 8.	Ноосны зах зээлийн дундаж үнэ болон урамшууллын хэмжээ	49
Зураг 9.	Хөдөөгийн өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, /дүнд эзлэх хувиар/	50
Зураг 10.	Ноосны урамшуулал болон урамшуулалд хамрагдсан малчдын тоо, бэлтгэсэн нийлүүлсэн ноос, ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний хамаарал	51
Зураг 11.	Арьс, ширний зах зээлийн дундаж үнэ ба нэгж арьс, ширэнд олгосон урамшууллын дундаж хэмжээ /мянган төгрөг/	56
Зураг 12.	Арьс, ширний урамшууллын хэмжээ болон урамшууллаар бэлтгэсэн арьс, шир, урамшуулалд хамрагдсан малчдын тоо, үйлдвэрлэлийн хамаарал	57
Зураг 13.	Санамсаргүй түүврийн судалгааны хамрах хүрээ	59
Зураг 14.	Малын тоо ба орлогын түвшин	61
Зураг 15.	Малчдад үзүүлсэн урамшууллын үр нөлөө	62
Зураг 16.	Малчдын урамшууллын талаарх санал, бодол	63
Зураг 17.	Тариаланчдын ажлын туршлага, өрхийн орлого ба урамшуулал	64
Зураг 18.	Улаан буудайн импортын болон дотоодын үнэ	73
Зураг 19.	Зарим улс орны хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн хувь хэмжээ	77

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн нэгдсэн улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ЕХ	Европын Холбоо
МАА	Мал аж ахуй
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
НҮБХХБХ	НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал
ОУВС	Олон улсын валютын сан
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын их хурал
УГТЭШХ	Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн салбарт төрийн үйлчилгээг үр ашигтай, хариуцлага тайлагналтай, хэрэгцээнд нийцсэн байдлаар хүргэх, мөн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцооны шинэчлэл, институтийн чадавх бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр Европын Холбооны санхүүжилтээр “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийг Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага ба Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран хэрэгжүүлдэг.

Төслөөс хэрэгжүүлж буй нотолгоо, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чухал оролцоотой Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ыг сонгон, туршилтын журмаар Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ)-ийн хөтөлбөрүүд, тэдгээрийн төсвийг үр дүн, нотолгоонд суурилсан аргачлалаар боловсруулах ажил хийгдэж байна.

Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны ажил нь салбарын бодлого, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан улсын төсвийн урамшуулал, дэмжлэгийн хэрэгжилт, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг судлах, салбарын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч нарт зориулан бодлогын хувилбарт санал дэвшүүлэх, зөвлөмж өгөх зорилготой юм.

Судалгааны ажлыг “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь” төслийн олон улсын болон үндэсний зөвлөхүүд гүйцэтгэв.

“Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл



1.

Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны үндэслэл, зорилго, арга зүй

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр (ХХААХҮ)-ийн салбар нь 2020 оны байдлаар Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 32.5 хувийг, нийт экспортын 5.6 хувийг, нийт ажиллагсдын 50 гаруй хувийг тус тус бүрдүүлж байна. Сүүлийн 10 жилд ХХААХҮ-ийн сайдын багцын төсвийн нийт зарлага нь 2011 оныг эс тооцвол ДНБ-ий 0.2-1.6 хувь, нэгдсэн төсвийн 0.8-4.2 хувь, улсын төсвийн 1.1-5.5 хувийг тус тус эзэлж байна. ХХААХҮ-ийн салбарт улсын төсвөөс санхүүжүүлсэн нийт дэмжлэг, урамшууллын хэмжээ нь 2010-2020 оны дунджаар тус салбарын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 34.1 хувь, урсгал зардлын 46.9 хувийг тус тус эзэлж, салбарын төсөвт томоохон жин дарж байна.

Тиймээс үр нөлөөтэй, үр дүнд суурилсан төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, төсвийн дэмжлэгийг үр дүнтэй ашиглахын тулд Монгол Улсын хөдөө аж ахуйг дэмжих бодлого, төсвийн дэмжлэг, урамшуулал буюу татаас шилжүүлгийн өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй арга хэлбэр, түүний үр нөлөө, үр дүнд шинжилгээ хийх, салбарын зорилт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангахад төсвийн зардлыг илүү үр дүнтэй, үр ашигтай зарцуулах шаардлагатай байна.

Энэхүү судалгаа нь цаашид салбарын урт, дунд хугацааны бодлого, зорилтууд, үр дүнг тодорхойлохдоо нотолгоо, судалгаанд суурилах, бодлого төсвийн уялдааг хангах, үр дүнд чиглэсэн төсвийн төлөвлөлт хийхэд дөхөм болно.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгааны ажлын зорилго нь салбарын бодлого, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан улсын төсвийн урамшуулал, дэмжлэгийн хэрэгжилт, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллийг судлах, салбарын бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч нарт зориулан бодлогын хувилбарт санал дэвшүүлэх, зөвлөмж өгөх зорилготой. Энэ хүрээнд дараах чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт гарган бодлогын зөвлөмж боловсруулав. Үүнд:

1. ХАА-н салбарын өнөөгийн төлөв байдал, хандлага, тулгамдаж буй асуудал, төсвийн нийт зарцуулалтын талаар судлах
2. ХАА-н салбарын урамшуулал, дэмжлэгийн бодлогын үр өгөөж, үр дүнтэй байдалд дүн шинжилгээ хийх
3. Улс орнуудын ХАА-н салбарт хэрэгжүүлж буй бодлого, дэмжлэгийг судалж, сайн туршлага, сургамжийг түгээх
4. ХАА-н салбарын урамшуулал, дэмжлэгийн үр нөлөө, үр дүнг сайжруулах талаар бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагч нарт зориулан зөвлөмж боловсруулах зэрэг болно.

1.3. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд 2010-2020 онд Монгол Улсын ХХААХҮ-ийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын төсвийн зарлага, түүний хуваарилалтын тойм, дэд салбар тус бүрээр ангилж, түүний хэрэгжилт, үр дүн, нөлөөлөл, аймаг тус бүрээр хуваарилсан урамшуулал, дэмжлэгийн бодлогын хэрэгжилтийг хамруулсан болно.

Мөн Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв болон Орхон аймгийн нийт сонгогдсон 14 сумын 300 гаруй иргэн оролцсон эмпирик судалгааны ажил хийсэн. Судалгаанд хамрагдсан аймаг, сумдыг дараах үндэслэлээр сонгосон. Үүнд:

- Сүүлийн 10 жилд (2010-2020 он) хамгийн их дэмжлэг, урамшуулал хүлээн авсан;
- Малын тооны нягтаршил, газар тариалангийн талбай, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ;
- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл хослон хөгжүүлж буй байдал зэрэг болно.

1.4. СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын дэмжлэг, урамшууллын бодлогын хүрээнд салбарын өнөөгийн байдал, төсвийн зарцуулалтын чиг хандлагад нөхцөл байдлын шинжилгээ хийж, холбогдох дүгнэлт гаргахад дараах арга зүйг ашигласан. Үүнд:

- Салбарын тэргүүлэх чиглэл, тулгамдаж буй сорилт, үйлдвэрлэл, орчны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, Улсын их хурал (УИХ), Засгийн газраас гаргасан бодлого, хууль, тогтоомж, тэдгээрийн зорилт, үр дүн, хэрэгжилтийн тайлан, судалгааны материалтай танилцаж, дүгнэлт гаргах;
- Салбарын статистик, тоон мэдээллийг цуглуулж, тулган баталгаажуулах, нэгтгэх, харьцуулах дүгнэлт гаргах;

- ХАА-н бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, урамшуулал, дэмжлэгийг хүртэгчид, оролцогч бусад талуудтай уулзан ярилцлага хийж, асуудлыг тодруулах, асуумж судалгаа хийн холбогдох мэдээлэл, баримтыг цуглуулан дүн шинжилгээ хийх тоон болон чанарын шинжилгээ хийх;
- Урамшуулал, дэмжлэгийн нөлөөлөл, үр дүнг үнэлэх регрессийн шинжилгээ, үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэгийн тооцоо /Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын арга хэрэгсэл/, бусад загварыг ашиглах зэрэг болно.

Судалгаа, шинжилгээнд ХАА-н салбарын бодлого, төсөв, урамшууллын төрөл, мөнгөн болон мөнгөн бус, орц болон гарцад суурилсан урамшууллын талаар дараах мэдээллийн дараах голлох эх сурвалжийг ашигласан. Үүнд:

1. Хууль, тогтоомж:

- УИХ, Засгийн газраас гаргасан хууль, тогтоомж, шийдвэрүүд, холбогдох мэдээлэл, материал;
- ХХААХҮ-ийн сайдын тушаал болон холбогдох материал;
- ХХААХҮ-ийн салбарын мэдээлэл, тайланг яамны цахим хуудас;
- Бусад эх сурвалжаас холбогдох баримт материал.

2. Өмнөх судалгаа, мэдээлэл, хяналт, шалгалтын ажлын тайлан

3. Тоон мэдээлэл:

- **Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээллийн сан** - <http://www.1212.mn> сайтаас статистикийн сар, улирал, жилийн эмхэтгэл, судалгааны ажлын тайланг ашиглан Монгол Улсын нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэл, ажиллах хүч болон ХАА-н салбарын үзүүлэлтүүдийг авав.
- **ХХААХҮЯ болон бусад байгууллагуудын гаргасан тайлан мэдээлэл;**
- **Олон улсын статистик мэдээллийн сан:** НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (НҮБХХБХ), Дэлхийн банк, Олон улсын валютын сан (ОУВС), ЭЗХАХБ, сонгосон бусад орнуудын ХАА-н дэмжлэг, урамшууллын талаарх албан мэдээлэл, тайлан, судалгаа, тоон мэдээлэл.

4. Асуумж судалгаанд оролцсон иргэд, малчид, тариаланчид, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага (ТББ)-уудын төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлагууд.

2.



Хөдөө аж ахуйн дэмжлэгийн талаарх олон улсын туршлага

2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Тогтвортой хөгжлийн зорилгод 2030 онд хүрэхэд ялангуяа, ядуу буурай улс орнуудын хөдөө аж ахуйн салбарт ихээхэн хөрөнгө оруулалт шаардлагатай гэдгийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн байдаг. Тухайлбал, “Өлсгөлөнг эцэс болгож, хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол тэжээлийн байдлыг сайжруулж, тогтвортой хөдөө аж ахуйг хөхүүлэн дэмжих” гэсэн Тогтвортой Хөгжлийн Зорилго 2-ыг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын төсөв болон хувийн хэвшил хамтран гаргах шаардлагатай.

Засгийн газрын бодлогын нэг чухал шинж чанар бол хөдөө аж ахуйн салбарын дэмжлэг хэлбэрээр олгосон Засгийн газрын төсвийн зарлага юм. Бодлогын төрөл бүрийн зорилгыг хангах үүднээс нөөцийн ашиглалтад нөлөө үзүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлдэг. Өндөр хөгжилтэй улс орнууд хөдөө аж ахуйн дэмжлэгийг өргөн ашиглаж ирсэн бол сүүлийн жилүүдэд шинээр хөгжиж буй улс орнууд мөн өндөр хурдацтайгаар ашиглах болсон байна. Тухайлбал 2022 онд ЭЗХАХБ-ын “Хөдөө аж ахуйн бодлогын хяналт үнэлгээ: Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох үүднээс хөдөө аж ахуйн бодлогыг шинэчлэн өөрчлөх” тайланд¹ хамрагдсан 54 улсын хөдөө аж ахуйн салбарт үзүүлсэн Засгийн газрын дэмжлэг 2019-2021 онд жилд дунджаар 819 тэрбум ам.доллар хүрсэн нь 2000-2002 оны жилийн дундаж түвшнээс 2.4 дахин, 2018-2020 оны жилийн дундаж түвшнээс 13 хувь тус тус өссөнийг дурдсан байна. Түүний дотор шинээр хөгжиж буй 11 улсын хөдөө аж ахуйн салбарын дэмжлэг жилд дунджаар 464 тэрбум ам.долларт хүрсний 60 орчим хувийг Хятад улс дангаар эзэлсэн байна. 2019-2021 онд жилд дунджаар үзүүлсэн дэмжлэгийн 500 тэрбум ам.долларыг Засгийн газрын төсвийн шилжүүлэг хэлбэрээр олгосон байна.

¹ OECD (2022) Agriculture Policy Monitoring and Evaluation 2022: Reforming agricultural policies for climate change mitigation

2.1 ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭМЖЛЭГИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ

Хөдөө аж ахуйн татаасын хувьд олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт хараахан байхгүй байна. Олон улсын байгууллага, тухайлбал, Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) болон ЭЗХАХБ-аас хөдөө аж ахуйн татаасыг тодорхойлох, ангилах, түүний хэмжээ далайц, үр нөлөөг тооцоход баримталсан арга барилыг энэхүү судалгаанд ашиглав. Тэд хөдөө аж ахуйн татааст Засгийн газраас уг салбарт үзүүлж буй бүхий л дэмжлэгийг хамруулдаг байна. Эдгээр байгууллагын хөдөө аж ахуйн дэмжлэгийн тодорхойлолт, ангиллыг харьцуулан Хүснэгт 1-д харуулав.

Хөдөө аж ахуйн дэмжлэгт төсвийн шууд шилжүүлэг, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн хязгаар тогтоох эсвэл түүхий эдийн дотоодын болон олон улсын зах зээл хоорондын үнийн зөрүү үүсгэх худалдааны хориг, хязгаарлалт тавих зэрэг зах зээлийн үнийн дэмжлэг тус тус багтаж байна. Харин аливаа шилжүүлэг үүсгээгүй хөдөө аж ахуйн бодлогыг хамруулдаггүй байна. Тухайлбал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эсвэл үнэд нөлөөлөх хууль, дүрэм, журмыг хөдөө аж ахуйн дэмжлэг гэж үздэггүй байна. Эдгээр байгууллагын хөдөө аж ахуйн дэмжлэгийн тодорхойлолт бараг адил бөгөөд тооцох аргачлалын хувьд л ялгаатай ажээ.

Хүснэгт 1. ЭЗХАХБ болон ДХБ-ын хөдөө аж ахуйн дэмжлэгийн ангиллын харьцуулалт

ЭЗХАХБ-ын ангилал			Жишээ	ДХБ-ны ангилал
Үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг	Бүтээгдэхүүн/ гарцад суурилсан дэмжлэг	Зах зээлийн үнийн дэмжлэг	Худалдааны хориг саадаас үүссэн (жишээлбэл, гаалийн тариф, гаалийн тарифын хувь хэмжээ, квот)	Татаас гэж үздэггүй
			Баталгаат үнийн доод хэмжээ (жишээлбэл, Засгийн газар захиргааны тогтоосон үнээр худалдан авалт хийх)	Тусгайлсан бараанд болон нийт бараанд үзүүлэх дэмжлэг
		Бүтээгдэхүүн/ гарцад суурилсан төлбөр	Тусгайлсан түүхий эдийн үйлдвэрлэлд үзүүлэх буцалтгүй тусламж	
	Орцын татаас	Хувьсах орц	Үр, бордоо, цахилгаан, хортон шавж устгал	Бага орлоготой эсхүл нөөц багатай үйлдвэрлэгчид үзүүлэх орцын татаас
		Үндсэн хөрөнгө бий болгоход	Хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл	Хөгжиж буй орнуудын хөрөнгө оруулалтын татаас
		Хөдөө аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээ	Хортон шавж, өвчинтэй тэмцэх	
	Талбай/малын тоо толгой/ борлуулалтын орлого/орлогод суурилсан төлбөр	Үйлдвэрлэлийн шаардлага	Хөнгөлөлттэй даатгал	
			Үйлдвэрлэлийн хязгаарлалтын хөтөлбөр	Үйлдвэрлэл хязгаарласан хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх шууд төлбөр
		Үйлдвэрлэлийн шаардлагагүй	Шууд төлбөр, орлогын дэмжлэг	Үйлдвэрлэлээс хамааралгүй орлогын дэмжлэг
			Нийгмийн хамгаалал	Орлогын даатгал болон нийгмийн хамгаалал
			Салбар орхисны нөхөн төлбөр	Үйлдвэрлэгчийн тэтгэвэр
			Ойжуулалт	Нөөцийн тэтгэвэр
			Хөдөө аж ахуйн нэгжийн шинэчлэлд үзүүлэх буцалтгүй тусламж	Хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламж
Хөгжлийн хоцрогдолтой бүс нутагт үзүүлэх дэмжлэг			Бүсийн тусламж	
Түүхий эдийн бус шалгуурт суурилсан төлбөр	Биологийн олон зүйлийн хамгааллын төлбөр	Байгаль орчны		
Нийтлэг үйлчилгээ	Мэдлэг, инновацын тогтолцоо	Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	Судалгаа	
		Үйлдвэрлэл өргөжүүлэх үйлчилгээ	Үйлдвэрлэл өргөжүүлэх үйлчилгээ	
		Хөдөө аж ахуйн нэгж дэх сургалт	Сургалтын үйлчилгээ	
	Хяналт, шалгалт	Хортон шавж, өвчинтэй тэмцэх төсвийн зардал	Хортон шавж, өвчинтэй тэмцэх	
			Хяналтын үйлчилгээ	
	Дэд бүтцийн хөгжил, засварын зардал	Ус судлалын дэд бүтэц	Дэд бүтцийн үйлчилгээ	
	Зарлал, сурталчилгаа	Зах зээлд гарах хөтөлбөр	Хөдөө аж ахуй эрхлэгчид үзүүлэх бусад үйлчилгээ	
Улсын нөөц бүрдүүлэх зардал	Хадгалалтын зардал	Улсын нөөц бүрдүүлэх		
Хэрэглэгчид үзүүлэх дэмжлэг		Тэжээлийн тусламжийн хөтөлбөр	Дотоодын хүнсний буцалтгүй тусламж	

Зах зээлийн “доголдол”-ыг засах, нийтийн бараа (public good)-гаар хангахад хөдөө аж ахуйн дэмжлэгийн гүйцэтгэх үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ улам бүр харилцан хамааралтай болж буй дэлхий дахинд нэгэнт хүлээн зөвшөөрсөн хөдөө аж ахуйн дэмжлэгийн “хөршдөө хохирол учруулах” сөрөг нөлөөг авч үзэх явдал чухал юм. Хөдөө аж ахуйн дэмжлэгийг шүүмжлэгчид, эсэргүүцэгчид түүнийг эдийн засгийн гажуудал, үр ашиггүй байдал үүсгэхийн хамт хөдөө аж ахуйн том, чинээлэг аж ахуйн эрхлэгчид үр шимийг голчлон хүртэж буй хуваарилалтын сөрөг үр дагавар, зах зээлийн үнэд тусгалаа олоогүй гадаад нөлөөллийг хурцатгах, үнийн гажуудал үүсгэх замаар байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө, хүнсний буруу хэрэглээг илүүтэй шүүмжилдэг.² Нөгөө талаас, хөдөө аж ахуйн дэмжлэг нь зах зээлийн доголдлыг засах бодлогын хариу арга хэмжээ, орлогын тэгш бус байдал, хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн амьжиргааг дэмжих эсхүл амин чухал нийтийн бараагаар хангах зэрэг төрийн бодлогын зорилгыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж хөдөө аж ахуйн дэмжлэгийг дэмжигчид үзэж байна.³

Олон улс орны Засгийн газрын өмнө тавигддаг бодлогын гол асуудал бол хөдөө аж ахуйн бүтээмжийн өсөлт болон байгаль орчны тогтвортой байдлыг хангах улмаар энэ хоёр зорилтын уялдаа эсхүл зөрчлийг тодорхойлох хөдөө аж ахуйн удирдлагын практикт хөшүүрэг болох бодлогыг хэрхэн боловсруулах, хэрэгжүүлэх явдал ажээ (DeBoe 2020 он). Энэхүү ерөнхий чиглэлийн дагуу (ЭЗХАХБ 2021 он & Динг нар 2021 он) хөдөө аж ахуйн салбарын дэмжлэгийн тусгайлсан зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:


- Хүнсний аюулгүй байдал
- Зах зээлийн дэмжлэг
- Хөдөө аж ахуй эрхлэгчийн орлого нэмэгдүүлэх
- Газар тариалангийн бүтээмжийг дээшлүүлэх
- Хөдөөгийн хөгжил
- Технологийн дэвшил, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл.

ЭЗХАХБ-ын гишүүн орнууд, АНУ, Хятад, Бразил, Колумби, Коста Рика, Индонези, Казакстан, Филиппин, ОХУ, Өмнөх Африк, Украин, Вьетнам улсын хөдөө аж ахуйн дэмжлэгийн мэдээллийг Зураг 1-д харуулав. Эдгээр улс дэлхийн хөдөө аж ахуйн нэмүү бүтээгдэхүүний 2/3 үйлдвэрлэдэг байна. (Ссарчингер нар 2020 он).

² Horlick, G. and Clarke, P. A. (2016), Rethinking Subsidy Disciplines for the Future, E15 Task Force on Rethinking International Disciplines, Policy Options Paper, Geneva: International Centre for Trade and Sustainable Development and World Economic Forum, <https://cht.hm/32cxj7D>.

³ Sykes, A. (2005), 'Subsidies and Countervailing Measures', in Appleton, A., Macrory, P. and Plummer, M. (eds) (2005), The World Trade Organization: Legal, Economic and Political Analysis, Boston, MA: Springer Verlag.

Зураг 1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭМЖЛЭГТ ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Эх сурвалж: Сеарчингер нар 2020 он

Хөдөө аж ахуйн дэмжлэг үзүүлж буй улс орнуудын байгалийн баялгийн нөөц, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, улс төр-эдийн засгийн байдлаас хамаарч дэмжлэгийн зорилго ихээхэн ялгаатай байна. Жишээлбэл, хөдөө аж ахуйн их дэмжлэг үзүүлдэг АНУ үнэ, ургац хураалтын эрсдэлийг шийдвэрлэхийн хамт хүн амын ядуу бүлэг хүнсний бүтээгдэхүүнийг боломжийн үнээр авах боломжийг бүрдүүлэхэд гол анхаарал тавьж байна. Европын Холбоо (ЕХ)-ноос үзүүлж буй хөдөө аж ахуйн дэмжлэгийн үндэслэл нь хөдөө аж ахуйн жижиг үйлдвэрлэгч нарт орлогын дэмжлэг үзүүлэх, эрчимжсэн хөдөө аж ахуй эрхлэхтэй холбоотой байгаль орчны сорилтыг шийдвэрлэх явдал байна. Хятад улс өсөн нэмэгдэж буй хүн амыг хүнсээр хангахын хамт хот, хөдөөгийн хүн амын орлогын тэгш бус байдлыг арилгах зорилго тавьжээ. Бразил улс хөдөө аж ахуйн жижиг, дунд болон том аж ахуй эрхлэгч хоорондын тэгш бус байдлыг бууруулах, өндөр бүтээмжийг хадгалах, ядуу хэрэглэгч нарыг хамгаалахад гол анхаарал тавьж байна. Япон зэрэг бусад улс орон хөдөө аж ахуй эрхлэгчдийн орлогын түвшнийг хамгаалах, хүнсний дотоодын хангамжийг нэмэгдүүлэх, байгаль орчны хамгаалалд хөдөө аж ахуйн салбарын гүйцэтгэх үүргийг хадгалахад гол анхаарал тавьж байна.

Бодлогын ялгаатай зорилгыг хангахын төлөө улс орнуудын ашиглаж буй арга хэрэгсэл бас өөр өөр байна. Тухайлбал, Бразил, Хятад, Энэтхэг, Индонез зэрэг шинээр хөгжиж буй томоохон улс орны хөдөө аж ахуйн хөтөлбөр, арга хэмжээний гол тулгуур хэрэгсэл нь үнийн дэмжлэг, орцод суурилсан дэмжлэг эсхүл хөрөнгө оруулалтын тусламж болж байна. Учир нь эдгээр арга хэрэгсэл харьцангуй богино хугацаанд үйлдвэрлэл нэмэгдэх, гажуудал харьцангуй багатай бусад дэмжлэгтэй харьцуулахад хэрэгжүүлэхэд хялбар байдаг байна. Гэтэл ЕХ-ны гишүүн улс орнууд, Япон улс шууд төлбөр, хөдөө аж ахуйн нийтлэг үйлчилгээнд илүүтэй анхаарал тавьдаг болж байна.

2.2 ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО, ДЭМЖЛЭГИЙН ХЭЛБЭР

Динг нарын судалгааны тайлан (2021 он)-д дурдсаны дагуу улс орнуудын Засгийн газар нь газар тариалангийн гарцыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахаас эхлээд ядуурлыг

бууруулах хүртэлх олон зорилгоор хөдөө аж ахуйн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Дэлхий дахины хөдөө аж ахуйн бодлогын үндсэн зорилго, түүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бодлогын дэмжлэгийн олон хэлбэрийг нэгтгэн Хүснэгт 2 харуулав. Улс орнууд салбар дундын хөдөө аж ахуйн бодлогын дараах үндсэн гурван зорилго дэвшүүлсэн байгаа нь нийтлэг байна (практикт бодит зорилго ялгаатай байж болно). Үүнд: (1) хөдөө аж ахуй эрхлэгчийн орлогын өсөлт, (2) газар тариалангийн бүтээмжийн сайжралт, (3) хөдөөгийн хөгжил болно.

Хүснэгт 2. Хөдөө аж ахуйн бодлогын зорилго, дэмжлэгийн хэлбэр

Хөдөө аж ахуйн бодлогын зорилго

1. Дотоодын үйлдвэрлэлээр өөрийн хэрэгцээг хангаж буйг нэмэгдүүлэх
2. Дотоодын хүнсний аюулгүй байдал, амьжиргааг хангах
3. Хөдөө аж ахуйгаас олох орлого, хөдөө аж ахуй эрхлэгчдийн орлогын тэгш хуваарилалтыг сайжруулах
4. Хот, хөдөөгийн орлогын тэгш бус байдлыг бууруулах
5. Хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх
6. Боловсруулалт, маркетингийн сүлжээний үр ашгийг дээшлүүлэх
7. Нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах
8. Хөдөөгийн хөгжлийг дэмжих
9. Байгаль орчны үр дүнг сайжруулах
10. Экспорт, ажлын байр нэмэгдүүлэх, зардал бууруулах, газар тариалангийн түүхий эдийг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгон хувиргах
11. Ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг хангах

Бодлогын дэмжлэгийн хэлбэр

1. Хөнгөлөлттэй зээл болон хөдөө орон нутагт олгох зээлийн шугам
2. Зах зээлийн үнийн дэмжлэг
3. Экспорт, импортын тариф
4. Хүүгийн татаас
5. Үйлдвэрлэлийн орцод суурилсан татаас
6. Татварын буцаан олголт (эсхүл чөлөөлөлт)
7. Үр дүнд суурилсан төлбөр
8. Үйлдвэрлэлийн гарцад суурилсан татаас
9. Үйлдвэрлэгч, боловсруулагчдыг орлогын алдагдлаас сэргийлсэн даатгал
10. Өртгийн сүлжээний дэд бүтэц, эсхүл тоног төхөөрөмжид оруулах улсын хөрөнгө оруулал

Эх сурвалж: Динг нар 2021 он

2.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭМЖЛЭГИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХАНДЛАГА

Ази тивийн улс орнуудын үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэгт хамгийн их хувь хэмжээг зах зээлийн үнийн дэмжлэг, гарцад суурилсан бусад дэмжлэг эзэлдэг байна. Хятад, Энэтхэг, Индонез, Филиппин улсын Засгийн газар будаа, үр тариа зэрэг гол түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат үнэ тогтоох хэлбэрээр зах зээлийн үнийн дэмжлэг үзүүлдэг байна. Энэхүү дэмжлэг нь урамшуулалтай үнийг барих замаар жижиг аж ахуй эрхлэгчдийг дэмжих зорилготой. Сүүлийн жилүүдэд энэхүү дэмжлэг ихээхэн өссөний улмаас түүний учруулж буй гажуудлын талаар санаа зовних болсон байна. (Bellmann 2019 он). Хөдөө аж ахуйн дэмжлэгийн шинэчлэлийг өргөн хүрээнд амжилттай нэвтрүүлсэн улс болох Шинэ Зеландын туршлагыг **Шигтгээ 1**-т өгүүлэв.

Сүүлийн жилүүдэд Европ, Америк тивийн улс орнуудад давамгайлж байсан зах зээлийн үнийн дэмжлэг Канадаас бусад улс оронд ерөнхийдөө буурсан ажээ. Канад улсын сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь өндөр хамгаалалттай нийлүүлэлтийн удирдлага, импортын хамгаалалтын үр шимийг үргэлжлэн хүртсээр байна. Бразил улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид хөнгөлөлттэй зээлээс гадна хөдөөгийн хөнгөлөлттэй даатгал, баталгаат үнийн дэмжлэг авдаг байна. Ядуу аж ахуй эрхлэгч нарт зориулан бага хүүтэй зээл олгох замаар орцод суурилсан татаас олгодог байна. Жижиг, дунд үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгч нарт хангалттай бус зээл олгоход хүргэж буй зах зээлийн доголдлыг засахад чиглэдэг байна. АНУ-ын сүүлийн үеийн бодлогын өөрчлөлтийн улмаас хөнгөлөлттэй даатгал, үр тарианы гарцын болон үнийн эрсдэлээс хөдөө аж ахуй эрхлэгч нарыг хамгаалах хандлага нэмэгдэж байгаа юм байна. 20 гаруй жилийн өмнө Европт эхэлсэн үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарсан дэмжлэгээс газрын хэмжээнээс хамаарсан дэмжлэгт аажмаар шилжих шилжилт үргэлжилж байна. Энэ шинэчлэлийн хандлагыг Швейцар улсын жишээгээр авч үзсэнийг **Шигтгээ 2**-т өгүүлэв.

Шигтгээ 1.

ШИНЭ ЗЕЛАНД УЛСЫН ШИНЭЧЛЭЛИЙН ТУРШЛАГА

Шинэ Зеланд улсын эдийн засгийн хямрал эдийн засаг дах Засгийн газрын оролцоог бууруулах шинэчлэлд хүргэжээ. Өөрчлөлт шинэчлэл хийхэд хугацаа шаардлагатайг сайтар ойлгосон байна. Ашгаа нэмэгдүүлэх үүднээс хөдөө аж ахуй эрхлэгч нар хариу арга хэмжээг хурдан авсан ч эдийн засгийн өсөлтийг сэргээх, ажилгүйдлийг бууруулахад урт хугацаа шаардсан байна. Хөдөө аж ахуй эрхлэгч өрхөд дэмжлэг үзүүлэх үүднээс тус улс үйлдвэрлэлийн хэмжээнээс үл хамаарах дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн ажээ. Ийнхүү Засгийн газар санхүүгийн байгууллагуудтай хэлэлцээр хийх явцад хөдөө аж ахуй эрхлэгч нарт шинэчлэлийн үешатыг даван туулахад шаардлагатай боломжит бүхий л дэмжлэг, зөвлөмжийг үзүүлснээр тэд шилжилтийг хохирол багатай амжилттай даван туулсан байна.

Эдийн засгийн бодлогын өөрчлөлт, ялангуяа, хөдөө аж ахуйн бодлогын шинэчлэлд хөдөө аж ахуйн эрхлэгч нар, түүний дотор өндөр татаастай хонины аж ахуй эрхлэгч нар хүчтэй өртсөн байна. Эдийн засгийн таатай бус нөхцөлийг даван туулах, хөдөө аж ахуйн бодлогын шинэ орчинд дасан зохицоход аж ахуй эрхлэгч нарт туслах үүднээс засгийн газар шилжилтийн зарим хөтөлбөр мөн хэрэгжүүлсэн байна. Эдгээр хөтөлбөр нь аж ахуйн эрхлэгч нарын өрийн дарамтыг зөөлрүүлэх зорилттой байсан ба тэдний өрийн зарим хэсгийг бүрэн чөлөөлжээ. Шилжилтийн ийм хөтөлбөр үр дүнгээ өгч, тооцоолж байснаас цөөн тооны аж ахуйн эрхлэгч нар хөдөө аж ахуйн салбарыг орхисон байна. (Шинэ Зеланд улсын анхан шатны үйлдвэрлэлийн яам 2017 он).

Хөдөө аж ахуйн салбарын өөрчлөлт шинэчлэлийн арга хэмжээг нийт 7 жил хэрэгжүүлжээ. Энэ хугацаанд засгийн газар зээлийн эргэн төлбөрт өөрчлөлт оруулах, нийгмийн халамжийн тусламж үзүүлэх гэсэн шилжилтийн арга хэмжээ авах замаар хөдөө аж ахуйн эрхлэгч нарыг дэмжсэн байна. Аж ахуйд эрхлэгч нарт олгож байсан төсвийн шууд шилжүүлгийг бараг бүрэн зогсоон зөвхөн байгалийн гамшгийн үед л үзүүлэхээр өөрчилжээ. 1980-аад оны үеийн түүхэн дээд хэмжээний дэмжлэгийн хэмжээнээс энэ төрлийн дэмжлэгийн хэмжээ маш доогуур ажээ.

Хөдөө аж ахуйн эрхлэгч нар өөрийн орлогын бууралтыг саармагжуулах стратеги хэрэгжүүлсэн байна. Нэгдүгээрт, тэд бүтээмж нэмэгдүүлэх, аж ахуйгаа солонгоруулах, зарлагаа хянах арга хэмжээ авсан байна. Амьжиргааны түвшнийг хадгалах үүднээс аж ахуйн эрхлэгч нарт хөдөө аж ахуйн бус санхүүжилт авахыг зөвшөөрсөн чухал ач холбогдолтой болсон байна. Зах зээлийн үнийн дэмжлэг, орлогын олон төрлийн дэмжлэгийн хөтөлбөрийг халсан ч бодлогын шинэ орчинд дасан зохицох стратеги арга

> Шигтгээ 1.

хэмжээний хамт экспортын үнийг чөлөөлснөөр хонины аж ахуй эрхлэгч нар 1987 оноос хойш орлогоо тогтворжуулах боломжтой болсон байна. (Шинэ Зеланд Улсын анхан шатны үйлдвэрлэлийн яам 2017 он).

Шинэчлэлийн гол сургамж

- Төсвийн хямрал нь засгийн газар зарлагаа танах шаардлагыг бий болгож, улмаар хөдөө аж ахуйн салбарт үзүүлдэг санхүүгийн дэмжлэгийг бууруулах нөхцөлийг бүрдүүлжээ.
- Шинэчлэлийн үе шатны эхнээс л шийдвэр гаргах үйл явцад нийт оролцогч тал, түүний дотор хөдөө аж ахуй эрхлэгч нарыг идэвхтэй оролцуулснаар шинэчлэлийг хүлээн зөвшөөрөх, улмаар амжилттай хэрэгжүүлэх магадлалыг ихээхэн нэмэгдүүлдэг.
- Бүх талын зөвшөөрсөн ил тод хуваарийн дагуу хөдөө аж ахуйн дэмжлэгийг халах шаардлагатай.
- Шинэчлэл, түүнд дасан зохицох үйл явц тодорхой хугацаа шаарддаг байна. Шинэ Зеланд улсын хөдөө аж ахуй эрхлэгч нар ашгаа нэмэгдүүлэх хариу арга хэмжээг хурдан авсан ч эдийн засгийн өсөлтийг сэргээх, ажилгүйдлийг бууруулахад урт хугацаа шаардсан ажээ.
- Шинэчлэлд дасан зохицох явцад өрхийн хэрэглээг дэмжих үүднээс засгийн газар үйлдвэрлэлийн хэмжээнээс үл хамаарсан дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авсан нь чухал үүрэг гүйцэтгэжээ.
- Импортыг хориглох нь бодлогын хамгийн муу хариу арга хэмжээ гэж үзжээ. Учир нь үнийн өсөлт, бүтээгдэхүүний чанарын доголдлыг хэрэглэгчид амсдаг байна. Бүтээгдэхүүн, зах зээлийн хөгжлийг хамгаалсан худалдааны бодлого нь салбарын хөгжлийг буруу чиглэлд залж, олон улсын тэргүүн технологи, техник орж ирэхэд саад болдог байна.
- Банкны салбартай хэлэлцээ хийх явцад нь хөдөө аж ахуйн эрхлэгч нарт дэмжлэг үзүүлбэл тэд шинэчлэлийн дасан зохицох шатыг даван туулж чаддаг байна.

Шигтгээ 2.

ШВЕЙЦАР УЛСЫН СҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАТААСЫН ШИНЭЧЛЭЛ

Швейцар улсын хөдөө аж ахуйн татаасын дийлэнхийг сүүний аж ахуйг дэмжсэн дэмжлэг эзэлдэг байжээ. Бяслалт үйлдвэрлэлийн зориулалтаар тушаасан сүүнд шууд төлбөр төлдөг байна. Швейцар улс хөдөө аж ахуйн салбарт 4 тэрбум швейцар франк буюу 4 орчим тэрбум ам.долларын дэмжлэг үзүүлдэг байна. Хоёр гол шалтгааны улмаас хөдөө аж ахуй эрхлэгч нарын бүтээмж буурсан тул шууд төлбөрийн асуудал тавигдсан байна. Нэгдүгээрт, бүтээмж нэмэгдүүлэх үүднээс капитал-ажиллах хүчний харьцааг өөрчлөх хөшүүрэг болгон өмчлөгчийн орлогын ашиг сонирхлыг хамгаалах орлогын дэмжлэг үзүүлсэн байна. Хоёрдугаарт, шууд төлбөр нь техникийн үр ашиггүй байдал нэмэгдэхэд хүргэсэн байна. Хэрэв тухайн аж ахуйн эрхлэгчид олгосон шууд төлбөр нь өндөр ашиг олоход хүргэвэл оролцогч талууд, ялангуяа менежер, ажиллагчид энэхүү өндөр ашгийг ямарваа хүчин чармайлт гаргалгүй олж байна.

1993 онд хөдөө аж ахуйн бодлогын томоохон шинэчлэл эхэлсэн. Шинэчлэлийн үр дүнд төрийн оролцоо багасч, хоёр гол төрлийн шууд төлбөрийг нэвтрүүлсэн. Үүнд:

- Ерөнхий шууд төлбөр
- Нийгмийн амьдралд нөлөө үзүүлэх болон органик хөдөө аж ахуйг дэмжсэн шууд төлбөр.

Хоёр дах төрлийн шууд төлбөрийг нөөцийг тогтвортой ашиглах хөшүүрэг бий болгох, бохирдлыг бууруулахын хамт хөдөө аж ахуй эрхлэгч нарт нэмэлт нөхөн олговор олгох зориулалтаар олгосон байна. Эрчимжсэн газар тариалангийн үйлдвэрлэл (хортон шавьж устгах бодис эсхүл ургамлын өсөлтийг тохируулагч бодис хэрэглэлгүйгээр) эрхэлснээр мөн төлбөр авч болно.

Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн бодлогын зорилгыг хэрэгжүүлэхэд шууд төлбөрийн тогтолцоог илүүтэй ашиглах үндсэн зорилгоор шинэчлэл хэрэгжүүлсэн. Шинэчлэлийн гол бүрэлдэхүүн нь мал аж ахуйн эрхлэгч нарт олгодог шууд төлбөрийг халж, өндөрлөг газрын бэлчээрийг илүүтэй ашигласан болон биологийн олон янзыг хамгаалах зорилгыг ханган биелүүлсэн аж ахуй эрхлэгч нарын төлбөрийг нэмсэн байна. Эрчимжсэн мал аж ахуйн эрхэлсний төлбөрийг халсан явдал нь халуун маргаан дэгдээж, маргаантай алхам гэж үзсэн байна. Улс төрийн хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц байхын тулд шинэчлэлийн үйл явцыг болгоомжтой боловсруулах шаардлага тулгарсан. (ЭЗХАХБ 2017 он).

Швейцар улсын Холбооны зөвлөл нь 2014-2017 оны Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх шинэчлэлийн дараагийн цуврал арга хэмжээг боловсруулахын тулд шууд төлбөрийн тогтолцоог нарийвчлан судлах үүргийг Холбооны Хөдөө аж ахуйн албанд өгсөн байна. Шинжилгээ, хэлэлцүүлгийн үр дүнд 2014-2017 оны Хөдөө аж ахуйн бодлогын төсөлд өөрчлөлт оруулсан. Олон талын сонирхлын тэнцвэрийг олоход шинэчлэл өөрчлөлт чиглэсэн байна. Орлогын дэмжлэг үзүүлэх үндсэн зориулалтаар олгож байсан нэг га талбайн ерөнхий төлбөрийг халахад шинэчлэлийн үндсэн асуудал оршиж байв. Худалдааг чөлөөлөх зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэ төлбөрийг дахин хуваарилах болсон байна. Бод болон ямаа малладаг уламжлалт хөдөө аж ахуйн салбартай тус улсын хувьд хивэгч малын төлбөрийг мөн халсан нь нэлээд шүүмжлэлд өртсөн ажээ. Улс төр, нийгмийн зүгээс шинэчлэлийг хүлээн зөвшөөрөхүйц болгох үүднээс шилжилтийн үеийн нөхөн төлбөрийн механизмыг нэвтрүүлэн ашигласан байна. (ЭЗХАХБ 2017 он).

Хөдөө аж ахуйн эрхлэгчдийн хувьд шууд төлбөрийн хэмжээ өмнөхөөс буурч эсхүл өссөн. Жишээлбэл, төлбөрийн шинэ тогтолцооны хүрээнд Альпийн нурууны аж ахуй эрхлэгч нар эрчимжсэн үйлдвэрлэл, биологийн олон зүйлийн төлбөр, эгц налуу газарт аж ахуйн эрхэлсний нэмэгдэл төлбөр авдаг болсон бол нам газрын бүст бод малын эрчимжсэн аж ахуй эрхлэгч нарт олгодог малын тоо толгойнд ногдуулсан төлбөрийг халсан байна. Эдгээр аж ахуй эрхлэгчид учирсан сөрөг нөлөө буюу хохирлыг бууруулах зорилгоор шинэчлэлийн багц арга хэмжээнд шилжилтийн үеийн нөхөн төлбөрийг тусгаж өгсөн байна. (ЭЗХАХБ 2017 он)

Шинэчлэлийн сургамж

- Хөдөө аж ахуйн шинэчлэлд зах зээлийн тогтолцоог дэмждэг, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалагч бүлэгтэй хамтран ажиллах замаар тэдний дэмжлэгийг авсан. Шинэчлэлийг урагшлуулахад чөлөөт худалдаа, байгаль орчны асуудлыг дэмжигч нартай хамтран ажилласан нь мөн ач холбогдолтой болсон байна.
- Улс төрийн тааламжтай орчин бүрдсэн боломжийг ашиглах. 2013 онд Швейцар улсын Парламентад Чөлөөт ногоон нам олонх болсноор өмнөх жилүүдэд бэлтгэсэн шинэчлэлийн багц арга хэмжээг дэмжин баталсан байна. 2014-2017 оны Хөдөө аж ахуйн бодлогыг консерватив Парламент батлах байсан уу гэдэг нь эргэлзээтэй байна.
- Хөдөө аж ахуйн эрхлэгч нарт учирсан хохирлыг бууруулах үүднээс шилжилтийн үеийн нөхөн төлбөр ашиглах. Хамгийн их маргаан дагуулж, хурцаар хэлэлцсэн шинэчлэлийн багц арга хэмжээний нэг бол нэг бодоор тооцсон шууд төлбөрийг халах байжээ. Зарим аж ахуй эрхлэгчийн нийт төлбөрийн дийлэнх хэсгийг энэхүү төлбөр эзэлж байсан байна. Орлогын энэ алдагдлыг нөхөх үүднээс шинэчлэлийн багцад шилжилтийн үеийн нөхөн төлбөрийг оруулж өгсөн байна.
- Өргөн хүрээнд хэлэлцэж, олон нийтийн оролцоог хангах. Шинжээчид (хөдөө аж ахуй эрхлэгчид, экологийн мэргэжилтэн, эдийн засагч зэрэг)-ийн ялгаатай байр суурийг мэдэх явдал чухал ажээ.

> Шигтгээ 2.

- Шинэчлэлийг дэмжих, сонирхлын бүлгийн дарамт, шахалтыг сөрөхөд нотолгоог ашиглах. Бодлогын шинэчлэл хийхийг эрмэлзэж буй засгийн газарт шинжлэх ухаан, эдийн засгийн сайн нотолгоо чухал хэрэгсэл болдог байна. Шинэчлэлийн үр шим, түүнийг хүртэгч нарыг тодорхойлох, өөрчлөлт шинэчлэл хийх зайлшгүй болохыг нотлох нь сонирхлын бүлгийн дарамт, шахалтыг сөрөх арга замыг хангахад туслах ажээ.
- Шинэчлэл урт бөгөөд төвөгтэй үйл явц гэдгийг хүлээн зөвшөөрөх. Авлигад автагдаагүй сайн засаглалын тогтолцоо, салбарын болон хөдөөд зохистой хөрөнгө оруулалт хийснээр л хөдөө аж ахуйн салбар өрсөлдөх чадвартай болно. (ЭЗХАХБ, 2017 он). Өмчлөлийн хязгаарлалт тавьсан өмнөх хууль эрх зүйн орчноос улбаалан хөдөө аж ахуйн салбарт өмчлөгч бөгөөд аж ахуй эрхлэгч нар зонхилдог байсан байна. Энэхүү хязгаарлалтыг үе шаттай халах буюу зөөлрүүлснээр өмчлөлийн шинэ хэлбэр бий болж, хөдөө аж ахуйн салбарт шинэ хөрөнгө оруулагчийг татахад хувь нэмэр оруулдаг ажээ. (Pedersen, Buchholst & Drejer P 2014 он).

Их Британийн Chatham House хараат бус судалгааны хүрээлэнгийн хэвлэсэн “Татаас ба тогтвортой хөдөө аж ахуй: бодлогын талбарын зураглал гаргах нь”⁴ бүтээлд дурдсан хөдөө аж ахуйн дэмжлэгийн төрөл тус бүрээр түүний тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөллийг Хүснэгт 3-д харуулав. Үйлдвэрлэл ба худалдаа, хөдөөгийн хөгжил ба амьжиргаа, хүнс ба тэжээл, тогтвортой хөгжил буюу байгаль орчин гэсэн хөгжлийн 4 чиглэлд хөдөө аж ахуйн дэмжлэгийн үзүүлэх нөлөөллийг хамгийн их сөрөг дагавар (гажуудал, хохирол)-тайгаас хамгийн эерэг (үр шимтэй, гажуудал үүсгэдэггүй) гэсэн 6 үнэлгээ өгсөн байна.

Хөдөө аж ахуйн дэмжлэгийн 3 үндсэн төрөл (үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг, нийтлэг үйлчилгээ, хэрэглэгчид үзүүлэх дэмжлэг)-өөс үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг хамгийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг бол хэрэглэгчид үзүүлэх дэмжлэг хамгийн эерэг нөлөөтэй байна. Гарц\ бүтээгдэхүүн болон орцод суурилсан үйлдвэрлэгчийн дэмжлэг нь үйлдвэрлэл, худалдаанд хамгийн их гажуудал үүсгэхийн хамт байгаль орчны тогтвортой байдалд хамгийн их хохирол учруулж болзошгүй байна. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, импортыг бууруулах уламжлалт арга хэмжээ нь хэт үйлдвэрлэлийг дэмжиж, улмаар хүнсний илүүдэл үүсэхэд хүргэдэг. Илүүдэл хүнсний бүтээгдэхүүнийг ихэнхдээ экспортын татаас үзүүлэх замаар олон улсын зах зээлд гаргахад мөн хүргэдэг. Энэ нь олон улсын зах зээлийн үнийн дарамтыг улам хурцатгаж, доод түвшинд хүртэл үнэ эрс унахад хүргэдэг байна. Байгаль орчныг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй нөхцөлд үйлдвэрлэлийг дэмжсэн дэмжлэг нь хөдөө аж ахуйн практикаас үүсэх сөрөг үр дагаврыг эрс нэмэгдүүлдэг. Энэхүү дэмжлэг эмзэг газрыг үйлдвэрлэлд ашиглах, хөдөө аж ахуйн тогтвортой бус эрчимжүүлэлтийг дэмжих буюу хортон шавьж устгал, бордоог хэтрүүлэн хэрэглэхэд хүргэдэг байна.

Эсрэгээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээтэй холбоогүй төлбөр нь гажуудал үүсгэх нөлөө багатай байдаг байна. Харин ч ийм төрлийн төлбөр нь зах зээлийн доголдлыг арилгах, нийтийн гол бүтээгдэхүүнээр хангахад дэмжлэг үзүүлэх боломжтой ажээ. Жишээлбэл, ЕХ олон төрлийн үр тариа тариалах, газрыг байнгын хамгаалалтад авах, тариалангийн газрын тодорхой хувийг экологийн зориулалтаар ашиглах зэрэг тодорхой шаардлагыг хангасан хөдөө аж ахуй эрхлэгч нарт шууд нөхөн төлбөр төлдөг байна.

⁴ Bellmann, C. (2019), Subsidies and sustainable agriculture: Mapping policy landscape, Chatham House December 2019

Салбарын нийт түвшинд үзүүлдэг дэмжлэгээс судалгаа, хөгжүүлэлт, хөдөө аж ахуйг эрчимжүүлэх үйлчилгээ, технологи шилжүүлэг нь хөдөөд оруулж буй хөрөнгө оруулалтаас хамгийн өндөр өгөөжтэй байдаг байна. Эдгээрийг ядуурлыг бууруулах, өлсгөлөнг халах гол хэрэгсэл гэж үздэг байна. Хэрэглэгчид үзүүлдэг дэмжлэг нь хүнсний хүртээмжийг хангахад төдийгүй ядуу иргэдийн хүнсний зохистой хэрэглээг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Худалдааны бодлогын хувьд ядуу хэрэглэгч нарын худалдан авах чадварыг дээшлүүлэх нь хүнсний аюулгүй байдал эсхүл тэжээлийн асуудлыг шийдвэрлэхэд ашигладаг үнийн хяналт эсхүл үйлдвэрлэлийг дэмжих зэрэг шууд бус төлбөрөөс илүү үр дүн, үр нөлөөтэй байна.

Бодлогын интервенцийн гол үндэслэл нь хүнс тэжээл эсхүл хүнсний аюулгүй байдал бол бэлэн хүнсээр хангахаас илүүтэй мөнгөн шилжүүлэг эсхүл хүнсний талон олгох хэлбэрээр хэрэглэгчид дэмжлэг үзүүлэх нь илүү зохимжтой хэрэгсэл болдог байна. Өөрөөр хэлбэл, дэмжлэг түүхий эд, бүтээгдэхүүнд бус иргэдэд чиглэх ёстой. Гажуудал гарах эрсдэлийг хязгаарлаад зогсохгүй үүссэн асуудлыг үйлдвэрлэлийг дэмжих замаар шийдвэрлэнэ гэж найдалгүй харин дэмжлэг шаардлагатай хэрэглэгчдэд тусгайлан зориулах боломжийг засгийн газарт мөн олгодог байна.

Бүтээмж нэмэгдүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилготой бол нийтлэг үйлчилгээний хэлбэрээр үзүүлж буй дэмжлэг нь гажуудал гаргалгүйгээр зорилго хангах хамгийн үр дүнтэй хэрэгсэл болж байна. Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн тогтолцоонд шилжих эсхүл нийтийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх бол байгаль орчин хамгааллын үйлчилгээний төлбөр, үйлдвэрлэлийн хэмжээтэй холбоогүй төлбөрийн бусад хэлбэр нь хамгийн оновчтой хэрэгсэл болдог байна. Гэвч эдгээр төлбөр нь уг төрлийн нийтийн бүтээгдэхүүнээр хангах өртөгтэй уялдах ёстой.

Сүүлийн хэдэн арван жилд ЕХ, АНУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй улс орны авч хэрэгжүүлсэн бодлогын өөрчлөлт, шинэчлэлийн үр дүнд худалдааны гажуудал үүсгэх хөдөө аж ахуйн дэмжлэг аажмаар буурч байна. Харин Хятад, Энэтхэг, Индонез, Турк зэрэг шинээр эрчимтэй хөгжиж буй улс орон дотоод нийлүүлэлтэд хөшүүрэг болох эсхүл жижиг хөдөө аж ахуй эрхлэгчдийн орлогыг дэмжих үүднээс хөдөө аж ахуйн дэмжлэгийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлсэн байна.

Нөгөө талаас, хөдөө аж ахуйн дэмжлэгийг цөөн тооны түүхий эд, бүтээгдэхүүнд голчлон олгосны улмаас том аж ахуй эрхлэхэд зохимжтой илчлэг ихтэй цөөн нэрийн үр тарианаас хамаарсан эрчимжсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хүргэсэн. Мөн биологийн олон зүйлийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх, цөөн нэр төрлийн хүнс зонхилсон хэрэглээтэй болдог байна. Эдгээр үр тариа илчлэг өндөртэй ч харьцангуй шим тэжээл багатай учраас тэдгээрийн үйлдвэрлэл өсөхийн хирээр дэлхийн хүн ам илүү илчлэг ихтэй, шим тэжээл багатай цөөн нэр төрөл бүхий хүнсний хэрэглээтэй болоод байна. Ингэснээр дэлхий даяар жингийн илүүдлийн аюул нүүрлэж, чихрийн шижин, шим тэжээлийн хомсдол, зүрхний өвчин зэрэг халдварт бус бусад өвчлөл нэмэгдэж байна.

Хүснэгт 3. Хөдөө аж ахуйн дэмжлэгийн тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөлөл

ХАА дэмжлэгийн төрөл		Үйлдвэрлэл болон худалдаа	Хөдөөгийн хөгжил, амьжиргаа	Хүнс, тэжээл	Тогтвортой хөгжил
Үйлдвэрлэгчид үзүүлэх дэмжлэг	Бүтээгдэхүүн/ гарцад суурилсан дэмжлэг	Өндөр гажуудалтай	Болзошгүй үр шимтэй боловч өндөр өртөгтэй бөгөөд зорилтот бүлэгт чиглээгүй, үр ашиггүй	Ихэнхдээ үр ашиггүй бөгөөд сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэй	Их хохирол учруулж болзошгүй
	Орцод суурилсан дэмжлэг	Өндөр гажуудалтай	Болзошгүй үр шимтэй боловч өндөр өртөгтэй бөгөөд зорилтот бүлэгт чиглээгүй, үр ашиггүй	Ихэнхдээ үр ашиггүй бөгөөд сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэй	Их хохирол учруулж болзошгүй
	Талбай/малын тоо толгой/ борлуулалтын орлого/орлогод суурилсан дэмжлэг	Гажуудал үүсгэхүйц	тодорхой бус	Ихэнхдээ үр ашиггүй бөгөөд сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэй	Ихэнхдээ үр ашиггүй бөгөөд сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэй
		Хамгийн бага гажуудалтай	тодорхой бус	Үр шимтэй байж болзошгүй	Үр шимтэй байж болзошгүй
Нийтлэг үйлчилгээ	ХАА талаарх мэдлэг, инновацийн тогтолцоо	Хамгийн бага гажуудалтай буюу гажуудал үүсгэдэггүй	Зорилтот бүлэгт чиглэсэн бол хамгийн өндөр үр ашигтай байх боломжтой	Шууд бус үр шимтэй	Тодорхой бус
	Хяналт, шалгалт	Хамгийн бага гажуудалтай буюу гажуудал үүсгэдэггүй	Шууд бус үр шимтэй	Үр шимтэй	Үр шимтэй
	Дэд бүтцийн хөгжил, засварын зардал	Хамгийн бага гажуудалтай буюу гажуудал үүсгэдэггүй	Хамгийн өндөр үр ашигтай байж болзошгүй ч өндөр өртөгтэй	Шууд бус үр шимтэй	Тодорхой бус
	Зар, сурталчилгаа	Хамгийн бага гажуудалтай буюу гажуудал үүсгэдэггүй	Хамгийн өндөр үр ашигтай байж болзошгүй	Шууд бус үр шимтэй	Тодорхой бус
	Улсын нөөц бүрдүүлэх зардал	Хамгийн бага гажуудалтай буюу гажуудал үүсгэдэггүй	Шууд бус үр шимтэй	Үр шимтэй ч өндөр өртөгтэй	Тодорхой бус
Хэрэглэгчид үзүүлэх дэмжлэг	Татвар төлөгчөөс хэрэглэгчид шилжүүлэх шилжүүлэг	Ерөнхийдөө гажуудал үүсгэдэггүй	Шууд бус үр шимтэй	Хамгийн өндөр үр шимтэй байх боломжтой ч алдагдал гарах эрсдэлтэй	Тодорхой бус

Эх сурвалж: Bellmann, C. (2019), *Subsidies and sustainable agriculture: Mapping policy landscape*, UK Chatham House December 2019

Тэмдэглэгээ: ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ



Ерөнхийдөө эерэг

Ерөнхийдөө сөрөг

3.




Хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар нь мал аж ахуй, газар тариалангийн дэд салбараас бүрддэг. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн хэрэгцээг хангахад зориулагдаж байна.

ХАА-н салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1996 онд Монгол Улсын ДНБ-ий 38.5 хувийг эзэлж байсан бол аажмаар буурч 2005 онд 19.8 хувь, 2020 онд 13.0 хувийг эзлэх болсон байна. Энэ нь өнгөрсөн хугацаанд уул уурхай, худалдаа, үйлчилгээ зэрэг салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж, үйл ажиллагаа, үйлдвэрлэл өргөжсөнтэй холбоотой.


Зураг 2. ХАА-Н САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



Эх сурвалж: УЦХ

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь байгаль, цаг уурын байдлаас ихээхэн хамааралтай байна. Тухайлбал, цас зудны улмаас 2010 онд 10.3 сая мал хорогдсон⁵ улмаас ХАА-н салбар 16.6 хувиар унасан бол цаг агаарын харьцангуй таатай байсан 2012-2015 онд дунджаар 16.2 хувийн өсөлттэй байсан байна. Тус салбар нь сүүлийн 5 жилд (2017-2021) дунджаар 2.4 хувь өсөөд байна (Зураг 3).

Зураг 3. ДНБ БОЛОН ХАА-Н САЛБАРЫН БОДИТ ӨСӨЛТИЙН ХАНДЛАГА



Сүүлийн 5 жил (2016-2020 он)-ийн дунджаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 84.1 хувийг мал аж ахуй, 15.9 хувийг газар тариалангийн салбар эзэлж байна.

Гадаад худалдааны статистик мэдээллээс харахад сүүлийн жилүүдэд нийт экспортод ХАА-н бүтээгдэхүүний экспортын эзлэх хувийн жин төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүний экспортыг оруулж тооцвол 2020 оны эцсийн байдлаар нийт экспортын 5.6 хувийг бүрдүүлж байна.

Хөдөө аж ахуйн салбарт 2020 оны байдлаар 180 мянга гаруй малчин өрхийн 298.8 мянган малчин, 1.5 мянган тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, 16.3 мянган тариаланч өрхүүд байгаа бөгөөд Монгол Улсын нийт ажиллагчдын 23.8 хувийг бүрдүүлж байна.

3.1. МАЛ АЖ АХУЙ

3.1.1 Өнөөгийн байдал


Мал аж ахуйн салбарт уламжлалт бэлчээрийн мал аж ахуй зонхилж байна. Мал тооллогыг жилийн эцэст явуулдаг болсон 1961 оноос эхлэн 1990 он хүртэл 30 жилийн хугацаанд буюу төлөвлөгөөт эдийн засгийн жилүүдэд Монгол Улсын мал сүргийн тоо дунджаар 23.1 сая толгой, хонин толгойд шилжүүлснээр⁶ 49.5 сая толгой малтай байсан байна.

⁵ Ү-ҮСХ, "Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2020" эмхэтгэл

⁶ ҮСХ, "Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2020" Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ 5 хонь, 1 адуу 7 хонь, 1 үхэр 6 хонь, 1 ямаа 0.9 хонь. https://1212.mn/BookLibraryDownload.aspx?url=huduu_aj_ahui_2019.pdf&in=Mn

Зах зээлийн эдийн засагт шилжиж, малыг хувьчилснаас хойш малын тоо өсөж, 2021 оны байдлаар 67.3 сая толгойд хүрчээ. Мал сүргийн бүтцийг авч үзвэл 46.2 хувийг хонь, 39.3 хувийг ямаа, 7.5 хувийг үхэр, 6.4 хувийг адуу, 0.7 хувийг тэмээ эзэлж байна. Зураг 4-д харуулснаар 1990 онтой харьцуулахад сүргийн бүтцэд ямааны эзлэх хувь ихээхэн нэмэгдэж бусад малын эзлэх хувийн жин буурсан байна. Ямааны тоо толгой болон хувийн жин нэмэгдсэн нь ямааны ноолуурын үнэ цэнэ өссөнтэй холбоотой.

Зураг 4. МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР



Эх сурвалж: ҮСХ

МАН-н салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох мах, сүү, ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой, бага зэрэг өсөх хандлагатай байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Гол нэр төрлийн малын гаралтай бүтээгдэхүүн

Төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Мах, мян.тн	263.4	299.3	291.7	448.0	400.0	426.2	515.2	545.0	744.5
Арьс, шир, сая ширхэг	8.6	11.0	10.2	15.2	14.0	14.5	19.3	19.6	27.1
Хонины ноос, мян.тн	17.5	20.2	22.3	25.8	27.4	30.6	33	33.7	35.6
Ноолуур, мян.тн	6.3	7.0	7.7	8.9	9.4	10.2	10.9	10.9	11.8
Сүү, сая литр	588.0	667.0	765.4	874.4	891.5	919.5	902.4	1074.2	1,082.4

Эх сурвалж: ҮСХ

Малчин өрхийн дундаж малын тоо өсөх хандлагатай байна. Тухайлбал 2012 онд 207.8 мянган малчин өрхийн 72 хувь нь 51-ээс дээш малтай байсан бол 2020 онд 79 хувь болж өссөн. Өнгөрсөн 8 жилийн хугацаанд 100-500 малтай өрхийн тоо 20 хувиар, 500-999 малтай өрхийн тоо 2.1 дахин, 1,000-аас дээш малтай өрхийн тоо 2.8 дахин тус тус өссөн байна. Нийт малчин өрхийн 63 орчим хувийг 100-1,000 хүртэлх малтай, 50 орчим хувийг 100-500 малтай өрхүүд тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. Малтай өрхийн тоо, малын тоо бүлэглэлээр

	2012	2020	2012	2020
Бүгд	207,818	242,024	100%	100%
51-100 малтай	32,902	32,411	16%	13%
101-200 малтай	48,474	51,185	23%	21%
201-500 малтай	50,468	67,958	24%	28%
501-999 малтай	14,276	30,327	7%	13%
1,000-1,499 малтай	3,046	8,454	1%	3%
2001-ээс дээш малтай	199	549	0.10%	0.23%
50 дээш малтай өрхийн эзлэх хувь			72%	79%

Эх сурвалж: ҮСХ

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд шувуу, зөгийн аж ахуй багахан хувийг эзэлдэг. Улсын хэмжээнд 2015 онд 100.6 сая ширхэг өндөг үйлдвэрлэж байсан бол 2019 оны эцсийн байдлаар 178.7 сая ширхэг өндөг үйлдвэрлэж 77.6 хувиар өссөн байна. 2015 онд 155.3 тонн зөгийн бал үйлдвэрлэж байсан бол 2019 онд 221.5 тонн буюу 2015 онтой харьцуулахад 46.6 хувиар нэмэгдсэн байна.

3.1.2 Мал аж ахуйн салбарт тулгарч буй асуудал, сорилт

Монгол Улсын мал аж ахуйн салбар нь дараах өвөрмөц онцлогтой. Үүнд:

- Байгаль, цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицсон нутгийн үүлдэр зонхилдог. Монгол үүлдрийн мал нь жилийн дөрвөн улиралд бэлчээрийн маллагаатай ба бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь улирлын шинж чанартай;
- Бүтээгдэхүүний гол нөөц нь төвлөрсөн зах зээл болох Улаанбаатар болон бусад томоохон хотуудаас алслагдсан, тархсан байршилтай;
- Уламжлалт мал аж ахуй нь хөдөлмөр их шингээдэг, нэг малын ашиг шим харьцангуй доогуур;
- Дотоодын зах зээлийн багтаамж бага;
- Түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн зохистой оновчтой тогтолцоо бүрдээгүй зэрэг онцлогтой.

Мал аж ахуйн салбарын дээрх онцлог нөхцөл байдалтай холбоотойгоор дараах сорилт тулгарч байна. Үүнд:

- Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлттэй холбогдуулан байгалийн гэнэтийн үзэгдэл, давагдашгүй хүчин зүйлийн эрсдэлийн нөлөөг бууруулах, дасан зохицох;
- Бэлчээрийн даац хэтэрч, цөлжилт явагдах хандлагатай байгаа тул мал сүргийн тоо, бүтцийг зохистой болгох;
- Мал сүргийн таваарлаг байдал, ашиг шимийг дээшлүүлэх;
- Хүнсний аюулгүй байдлыг хангах, түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэхийн тулд мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах;
- Улаанбаатар, хүн ам төвлөрсөн бусад томоохон хот суурин газрын хүнсний хангамжийг дээшлүүлэхийн тулд мах, сүүний эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх;
- Тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, байгалийн тэжээлийг орлох таримал тэжээлийг тариалах шаардлага бий болж байна.

3.1.3 Мал аж ахуйн салбарын тэргүүлэх чиглэл, бодлогын зорилт

Мал аж ахуйн салбарын харилцааг зохицуулж буй дараах гол хуулиуд үйлчилж байна. Үүнд:

1. Малын генетик нөөцийн тухай хууль;
2. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль;
3. Хоршооны тухай /шинэчилсэн найруулга/ хууль;
4. Малын тоо толгойн албан татварын тухай хууль;
5. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль.

Мөн тус салбарын урт, дунд хугацааны тэргүүлэх чиглэл, бодлогын зорилтыг агуулсан дараах баримт бичгүүд байна. Үүнд:

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;
2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө;
5. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого;
6. "Монгол малчин" үндэсний хөтөлбөр;
7. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, салбарын үндэсний хөтөлбөрүүдэд МАА-н салбарыг хөгжүүлэх, төрөөс дэмжих бодлогыг багцлан авч үзвэл дараах зорилтод чиглэж байна. Үүнд:

1. Бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх;
2. Бүс нутгийн онцлог, ашиг шимийн чиглэлээс хамаарч малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохист бүтцийг бүрдүүлэх эдийн засгийн хөшүүргийг бий болгох;
3. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах;
4. МАА-н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах, экспортыг нэмэгдүүлэх, экспортын зорилтот зах зээлийг судлан тогтоох;
5. Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлэх;
6. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, тээвэр, логистикийн тогтолцоог сайжруулах;
7. Салбарын хүний нөөцийг системтэй тогтвортой бэлтгэх, чадавхжуулах, үйлдвэрлэл эрхлэх менежментийг сайжруулах.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төрөөс бүтээгдэхүүний нийлүүлэлтэд урамшуулал олгох, бэлтгэн нийлүүлэлтэд хөнгөлөлттэй зээл, хүүгийн татаас олгох, хадлан тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмж нийлүүлэхэд татвар, үнийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг дэмжлэг үзүүлж иржээ. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд олон улсын байгууллага, гадаад улсын хөнгөлөлттэй зээл, тусламжийг авч зохих дэмжлэг үзүүлж ирсэн байна.

3.2 ГАЗАР ТАРИАЛАН

3.2.1 Өнөөгийн байдал

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжийн тоо 2014 онд 1.4 мянга байсан бол 2020 онд 1.5 мянгад хүрч өсжээ. Харин газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх өрхийн тоо 2014 онд 20.5 мянга байсан бол 2020 онд 16.3 мянга болж буурсан байна.

Газар тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн 51.9 хувь нь Төвийн бүсэд, 20.9 хувь нь Хангайн бүсэд, 14.6 хувь нь Баруун бүсэд, 8.7 хувь нь Зүүн бүсэд тус тус үйлдвэрлэл явуулж байна.

Хүснэгт 6. Тариалан эрхэлж байгаа аж ахуйн нэгж болон өрхийн тоо

	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Аж ахуйн нэгж	1,352	1,395	1,414	1,447	1,422	1,401	1,498
Өрхийн тоо	20,459	18,440	17,145	15,985	15,862	14,728	16,292

Эх сурвалж: ҮСХ

Газар тариалангийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнд үр тариа, төмс, хүнсний ногоо, таримал тэжээл орж байна. Техникийн ургамал, эмийн болон бусад ургамал, жимс, жимсгэнэ багахан хувийг эзэлдэг. Үр тарианы тариалалт 2020 оны байдлаар нийт тариалсан талбайн 69.4 хувийг, үүний дотор улаан буудайн тариалалт 64.1 эзэлж байна /Хүснэгт 7/.

Хүснэгт 7. Газар тариалангийн үйлдвэрлэл, тариалсан талбай

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Тариалсан талбай (мян.га)											
Нийт	316.4	347.4	381.7	418.0	444.4	527.7	508.3	527.0	511.8	526.0	588.0
Үр тариа	259.2	299.9	306.2	293.3	315.0	390.7	377.8	390.9	366.8	369.4	407.9
Буудай	250.2	291.4	297.3	275.6	291.2	361.2	355.1	365.7	342.4	343.5	377.0
Төмс	13.8	15.4	16.8	15.5	13.2	12.8	15.0	15.1	12.9	14.9	19.0
Хүнсний ногоо	7.0	7.8	7.9	8.3	8.7	7.7	9.1	8.4	8.9	8.4	10.6
Тэжээлийн ургамал	11.1	10.9	13.8	14.4	17.0	23.8	29.9	26.0	46.3	43.8	84.5
Жимс, жимсгэнэ	1.1	1.5	1.9	2.7	2.7	2.7	3.0	2.7	3.9	3.0	3.3
Хураан авсан ургац: (мян.тн)											
Үр тариа	355.1	446.1	479.4	387.0	518.8	216.3	483.5	238.1	453.8	433.3	430.3
Буудай	345.5	435.9	465.3	368.5	488.3	204.0	467.1	231.4	436.1	411.4	406.1
Төмс	168.0	201.6	245.9	191.6	161.5	163.8	165.3	121.8	168.9	192.2	244.3
Хүнсний ногоо	82.3	99.0	99.0	101.8	104.8	72.3	94.4	82.1	100.7	99.5	121.2

Тэжээлийн ургамал	34.8	40.4	46.2	42.6	44.3	49.2	53.4	47.9	123.8	121.1	182.1
Жимс, жимсгэнэ	0.578	1.8	0.595	1.6	1.2	1.4	1.6	1.5	1.7	1.8	1.6

Эх сурвалж: ҮСХ

Сүүлийн 5 жилийн хандлагаас харахад хураасан ургацын өсөлт, бууралт бүтээгдэхүүний нэр төрлөөс хамааран харилцан адилгүй байна. Тухайлбал, хураасан улаан буудай, төмс, хүнсний ногооны хэмжээ хэлбэлзэж ирсэн бол таримал тэжээлийн хэмжээ жилээс жилд нэмэгдсэн дүнтэй байна /Хүснэгт 7/.

Газар тариалангийн салбар байгаль, цаг уурын байдлаас ихээхэн хамааралтай байгаа нь тухайн жилийн хураан авсан нийт ургац болон га-гийн ургацын хэмжээнээс харагдаж байна. Тухайлбал цаг уурын нөхцөл таагүй байсан 2015, 2017 онд улаан буудай, 2017 онд төмсний га-гийн ургац мэдэгдэхүйц буурсан байна /Хүснэгт 8/. Мөн тухайн онуудад улаан буудайн га-гийн ургацын хэмжээ буурснаас нийт хураасан улаан буудайн хэмжээ ихээхэн буурсныг Хүснэгт 8-аас харж болно.

Хүснэгт 8. Улаан буудай, төмсний ургацын хэмжээ

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Дундаж
Нийт хураасан улаан буудай, мян.тн	345.5	435.9	465.3	368.5	488.3	204.0	467.1	231.4	436.1	411.4	406.1	387.2
1 га-аас хураасан улаан буудай, цн	13.8	15.0	15.6	13.8	16.8	5.6	13.2	6.3	12.7	12.0	10.8	12.3
1 га-аас хураасан төмс, цн	121.6	131.1	146.2	123.6	122.3	127.5	110.0	80.4	130.7	128.7	128.4	122.8

Эх сурвалж: ҮСХ

Манай Улсын хувьд 1 га-гаас хураан авч буй улаан буудайн ургац дэлхийн дунджаас ойролцоогоор 3 дахин доогуур байна. Байгаль цаг уурын нөхцөл ихээхэн таатай, ХАА-н хөгжил өндөр түвшинд хүрсэн Шинэ Зеланд, Англи зэрэг улсад 1 га-гаас дунджаар 80-90 центнер буудай хураан авч байна. Манай Улсын хувьд 2010-2020 онд 1 га-аас дунджаар 12.3 центнер улаан буудай хураан авчээ.

Дотоодын газар тариалангийн үйлдвэрлэлийн нийт дотоодын зах зээлд эзлэх хувийн жинг Хүснэгт 9-д харууллаа. Уг хүснэгтээс харахад сүүлийн 6 жилийн дунджаар улаан буудайн 82.7 хувь, төмсний 98.0 хувь, хүнсний ногооны 55.9 хувийг дотоодын үйлдвэрлэлээс нийлүүлсэн байна.

Хүснэгт 9. Газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл ба нийт нийлүүлэлтийн харьцаа, /хувиар/

Үзүүлэлт	Дотоодын үйлдвэрлэл/Нийт дотоодын зах зээлд нийлүүлэлт (%)					
	2015	2016	2017	2018	2019	2020*
Улаан буудай	90.7	74.3	94.3	64.9	96.4	75.9
Төмс	90.6	99.4	100.0	98.2	99.5	100.0
Хүнсний ногоо	57.4	57.4	52.0	54.2	54.3	60.3

Эх сурвалж: ХХААХҮЯ

Газар тариалангийн эрчимжилтийг харуулах нэг үзүүлэлт нь усалгаатай талбайн хэмжээ бөгөөд манай улсын нийт тариалсан талбайд усалгаатай талбайн эзлэх хувь бага боловч нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2015 онд нийт тариалсан талбайд усалгаатай талбайн эзлэх хувь 8.6 байсан бол 2020 онд 10.2 хувь байна.

Хүснэгт 10. Нийт тариалсан талбайд усалгаатай талбайн эзлэх хувь

Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020
	мянган га					
Нийт тариалсан талбай	527.7	508.3	527	511.8	526.0	588.0
Үүнээс усалгаатай талбай	45.2	35.7	36	36.5	47.3	60.2
Нийт дүнд эзлэх хувь	8.6	7	6.8	7.1	9.0	10.2

Эх сурвалж: ХХААХҮЯ

3.2.2 Газар тариалангийн салбарт тулгарч буй асуудал, сорилт

Тус салбарт ойрын хугацаанд дараах сорилт тулгарч байна. Үүнд:

- Байгаль, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл өндөр хэвээр байна.
- Усалгаатай тариалангаас бусад тариалангийн ургац цаг уурын нөхцөлөөс маш өндөр хамааралтай. Байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах, саармагжуулах даатгал болон бусад хэрэгслийг нэвтрүүлэх хэрэгцээ байна.
- Шинэ технологи, инновацын нэвтрэлт удаан, техник тоног төхөөрөмжийн хангамж сайнгүй, бүтээмж, үр ашиг доогуур /га-гийн ургац/ байна. Үүнд онцгой анхаарч үр дүнтэй бодлого, дэмжлэг, хөшүүргийг тодорхой болгох хэрэгтэй.
- Хүнсний ногооны дотоодоос нийлүүлэх үрийн хэмжээ нийт хэрэгцээг хангахгүй, импортын өндөр хамааралтай байна. Үрийн аж ахуйг зах зээлийн нөхцөлд зохицуулан хөгжүүлэх шаардлагатай.
- Хөрсний үржил шим, чанар муудах хандлагатай, тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас хангалтгүй байгаад анхаарч байгаль орчныг хамгаалах, мод тарих, цөлжилттэй тэмцэх бодлогын хэрэгжилттэй уялдуулах.
- Төмс, хүнсний ногоог хадгалах зорь, агуулах хангалтгүй байгааг шийдэх эдийн засгийн арга, хэрэгслийг ашиглах.
- Тээвэр, логистикийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

3.2.3 Газар тариалангийн салбарын тэргүүлэх чиглэл, бодлогын зорилт

Газар тариалангийн салбарын харилцааг зохицуулж буй гол хуулиуд, тэдгээрийн зорилгыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 11. Газар тариалангийн салбарын харилцааг зохицуулж буй хуулиуд

Хуулийн нэр	Хуулийн зорилго
1. Тариалангийн тухай	Тариалан эрхлэх, тариалангийн бүс нутгийг тогтоох, тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрсийг хамгаалах, сайжруулах, тариалангийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах
2. Үрийн тариалангийн даатгалын тухай	Үрийн тариаланг албан журмаар даатгуулахтай холбогдсон даатгалын компани болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах
3. Таримал ургамлын үр, сортын тухай	Таримал ургамлын үрийн салбарын хөгжлийг дэмжих, үрийн салбарын судалгаа, шинжилгээ, инновацыг хөгжүүлэх, үрийн шударга худалдааг төлөвшүүлэх, генетик нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, таримал ургамлын шинэ сорт бүтээх, сорт бүтээгчийн эрхийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах
4. Ургамал хамгааллын тухай	Бэлчээрийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах
5. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	Хөрсийг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтөөс сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах
6. Хүнсний тухай	Хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах

Тус салбарын урт, дунд хугацааны тэргүүлэх чиглэл, бодлогын зорилтыг агуулсан дараах баримт бичиг байна. Үүнд:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;
2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө;
5. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого;
6. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр;
7. “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөр.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, салбарын үндэсний хөтөлбөр, стратеги төлөвлөгөөнд дэвшүүлсэн газар тариалангийн салбарыг хөгжүүлэх, төрөөс дэмжих бодлогын тэргүүлэх чиглэл, зорилгыг багцалж дор дурдав. Үүнд:

- Тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд бүрэн оруулж, тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжсэн мал аж ахуйтай хослон хөгжүүлж, тэдгээрийг эрхлэх бүс нутгийг оновчтой тогтоох;

- > Эдийн засгийн үр ашигтай, хөрсний үржил шимд ээлтэй таримал, сортыг нутагшуулах, бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ирээдүйтэй, баталгаажсан таримал үрийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн үрээр хангах, үр, сортын тариалан, үрийн аж ахуйн тогтолцоог зах зээлийн нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх;

- > Хөрсний бүтэц, үржил шимд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологид суурилсан машин, тракторыг сонгож парк бүрдүүлэх, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, техникийн засвар үйлчилгээний тогтвортой сүлжээ байгуулах, зарим машин, багаж, эд ангийг дотооддоо үйлдвэрлэх, угсрах үйл ажиллагааг дэмжих;

- > Усны хайгуул, судалгаанд тулгуурлан гадаргын болон бороо, цасны усыг хуримтлуулах, услалтын системийн ашиглалтыг сайжруулах, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх;

- > Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн тариалалтад ус, эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд халгүй дуслын болон хөрсөн доороос нэвчүүлэх усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

- > Химийн гаралтай бордоо, ургамал хамгааллын бэлдмэлийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг төлөвшүүлэх;

- > Жимс, жимсгэнийн тариалалт, нэр төрлийг нэмэгдүүлэх;

- > Үр тариа, буурцагт болон бусад таримлын төрөл, сортыг нэмэгдүүлэх, буудай, төмс, хүнсний ногоо, тосны ургамлын үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улмаар экспортын чиг баримжаатайгаар хөгжүүлэх;

- > Эрчимжсэн мал аж ахуйг бүх төрлийн тэжээлээр хангах, уургийн өндөр агууламжтай таримлыг нутагшуулах, сортын үрийн нөөц бүрдүүлэх;

- > Өвөл, зуны хүлэмжийн болон зоорийг аж ахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хот, суурин гийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах зэрэг болно.

4.



Хөдөө аж ахуйн салбарын төсвийн зарцуулалт, дэмжлэг, урамшуулал

4.1 ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛАЛ, АНГИЛАЛ

Аль ч улс оронд хөдөө аж ахуйн салбар нь хөдөлмөр их шингээдэг, уур амьсгалын өөрчлөлт, ган зудад өртөмтгий буюу харьцангуй эрсдэл өндөртэй, ядуурал, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хангамж, биологийн төрөл зүйл, байгаль орчны тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлэхүйц салбар тул төрийн оролцоо, зохицуулалт ихтэй байх хандлагатай байдаг.

Монгол Улсын хувьд зөвхөн хоёр улстай хиллэдэг, хөдөө аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бэлтгэн нийлүүлэлт нь олон улсын зах зээл болоод дотоодын төвлөрсөн зах зээлээс харьцангуй хол байрлалтай, бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь улирлын шинж чанартай бөгөөд улс орны хүнсний хангамж, аюулгүй байдал, ажил эрхлэлт, хөдөөгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь чухал нөлөөтэй.

Мөн Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар нь байгаль цаг уураас ихээхэн хамааралтай, бүтээмж доогуур, бэлтгэн нийлүүлэлт, тээвэр, агуулахын сүлжээ сул хөгжсөн тул төрийн зохицуулалт, дэмжлэг шаардлагатай байдаг.

Зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн 1990-ээд оноос хойш төрөөс хөдөө аж ахуйн салбарын хууль, эрхзүйн тогтолцоог шинэчлэх, салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, хүнсний хангамжийг сайжруулах, малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчлэл хийх, цаг уурын эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлого, хөтөлбөр гарган хэрэгжүүлж ирсэн байна.

Энэ хүрээнд хөдөө аж ахуйн урамшуулал, дэмжлэгийг үзүүлж ирсэн. Манай улсын хувьд дээр дурдсан ЭЗХАХБ-ын ангилалд байгаа тодорхой нэр төрлийн урамшуулал, дэмжлэгийг ХАА-н салбарт үзүүлж ирсэн. Үүнийг Хүснэгт 12-д тоймлон авч үзлээ.

Хүснэгт 12. Монгол Улсад хэрэгжүүлж буй ХАА-н дэмжлэг, урамшуулал

ЭЗХАХБ-ын ангилал		Монгол Улсад хэрэгжүүлж ирсэн харгалзах урамшуулал, дэмжлэг
1	Зах зээл болон үйлдвэрлэгчдийг шууд дэмжих арга хэмжээ	
	Зах зээлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ	
	Үйлдвэрлэгчийг шууд дэмжсэн арга хэмжээ	
	-Үйлдвэрлэлийн хэмжээнд суурилсан шууд төлбөрүүд	Ноос, ноолуур, арьс шир, сүү, улаан буудайн татаас (урамшуулал)
	-Хувьсах орцын татаас	Таримлын үр, суулгац, түлш шатахуун, бордоо, пестицидийн дэмжлэг
	Үйлдвэрлэгчдэд олгосон гамшгийн төлбөр болон бусад нөхөн төлбөр	
2	-Нэгж талбай эсвэл мал дээр үндэслэсэн нөхөн төлбөр	Гоц халдварт өвчний үед малын устгалд зориулсан нөхөн төлбөр
	Бүтцийн өөрчлөлт болон хөдөөгийн хөгжилд чиглэсэн арга хэмжээ	
	ХАА-н салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээ	ХАА-н салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээнүүд
	ХАА-н бүтцийг сайжруулахад чиглэсэн дэмжлэг	Эрчимжсэн МАА-г хөгжүүлэх дэмжлэгүүд
	ХАА-н гаралтай хүнсний үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлтийн дэмжлэг	
	Ойн аж ахуйг дэмжих	
	Байгаль орчин, хөдөөгийн хөгжилд чиглэсэн дэмжлэг	Бэлчээр хамгаалах арга хэмжээ, худаг гаргах
	Хөдөөгийн хүн ам, эдийн засгийг дэмжих арга хэмжээ	Хөдөөгийн хүн ам, эдийн засгийг дэмжих бусад арга хэмжээнүүд
Орон нутгийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ	Чадавх бэхжүүлэх сургалтууд	
3	ХАА-тай холбоотой ерөнхий дэмжлэг	
	Судалгаа, хөгжүүлэлт, зөвлөх болон шинжээчийн үйлчилгээ	ХАА-н салбарын судалгаа, шинжилгээ
	Мэргэжлийн сургалтын дэд бүтэц	
	Мэргэшсэн үйлчилгээ	Мал эмнэлгийн үйлчилгээ
	Хүнсний аюулгүй байдал, чанарын хяналт	Хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтын арга хэмжээнүүд
	Мал эмнэлгийн хяналт	Мал эмнэлэг, хорио цээрийн мэргэжлийн хяналт
	Ургамлын эрүүл мэндийн хяналт	Ургамлын эрүүл мэндийн мэргэжлийн хяналт
4	Малчид, тариаланчдын болон бусад ТББ-уудад зориулсан дэмжлэг	Малчид, тариаланчдын хоршоодыг дэмжих арга хэмжээнүүд, загвар хоршоо
	ХАА-ын бодлогын бусад арга хэмжээ	Холбогдох арга хэмжээ

Мөн дэмжлэгийн хэлбэрээс хамааруулан мөнгөн болон мөнгөн бус гэж ангилж болно. Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын мөнгөн дэмжлэгт ноос, ноолуур, арьс шир, улаан буудай, мах, сүүний татаас орох бөгөөд эдгээр нь салбарын төсвийн зарлагад өндөр хувийн жин эзэлдэг.

4.2 ХХААХҮ-ИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРДАЛ, ТҮҮНИЙ БҮТЭЦ

ХХААХҮ-ийн салбарын улсын төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн нь сүүлийн 10 жилийн дунджаар Монгол Улсын ДНБ-ний 1.1 хувь, нэгдсэн төсвийн зарлагын 3.0 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 13. ХХААХҮ-ийн салбарын улсын төсвийн зарлага /тэрбум төгрөг/

Он	Нийт зарлага ба цэвэр зээл	Үүнээс:			ДНБ, оны үнээр	Нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх хувь			Нийт зарлага ба цэвэр зээлийн ДНБ-д эзлэх хувь
		Урсгал зардал	Хөрөнгийн зардал	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл		Урсгал зардал	Хөрөнгийн зардал	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	
	1	2	3	4	5	2:1	3:1	3:1	1:5
2010	129.9	81.7	35.6	12.5	9,756.6	62.9%	27.4%	9.6%	1.3%
2011	514.2	92.1	62.6	359.4	13,173.8	17.9%	12.2%	69.9%	3.9%
2012	180.7	78.8	77.0	25.0	16,688.4	43.6%	42.6%	13.8%	1.1%
2013	178.0	93.5	54.2	30.4	19,174.2	52.5%	30.4%	17.1%	0.9%
2014	134.8	101.5	50.3	-16.9	22,227.1	75.3%	37.3%	-12.6%	0.6%
2015	57.4	89.9	4.8	-37.3	22,894.8	156.6%	8.4%	-65.0%	0.3%
2016	142.2	113.5	23.0	5.7	23,931.3	79.8%	16.2%	4.0%	0.6%
2017	272.5	99.5	48.9	124.0	28,010.7	36.5%	18.0%	45.5%	1.0%
2018	172.5	102.6	27.6	42.3	32,582.6	59.5%	16.0%	24.5%	0.5%
2019	167.2	121.7	40.2	5.3	37,839.2	72.8%	24.0%	3.2%	0.4%
2020	347.9	307.8	20.6	19.5	37,453.3	88.5%	5.9%	5.6%	0.9%
Дундаж	208.8	116.6	40.4	51.8	23975.6	67.8%	21.7%	10.5%	1.1%

Эх сурвалж: ХХААХҮЯ

ХХААХҮ-ийн салбарын улсын төсвийн зарлага ба цэвэр зээлийн бүтцийг авч үзвэл сүүлийн 10 жилийн дунджаар 67.8 хувийг урсгал зардал, 21.7 хувийг хөрөнгийн зардал, 10.5 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна.

Урсгал зардлын бүтцийг харахад сүүлийн 10 жилийн дунджаар нийт урсгал зардалд бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь 47.8 байгаа бол түүнд татаас, шилжүүлгийн эзлэх хувь 52.2 байна. Хүснэгт 14-өөс харахад урсгал зардалд татаас, шилжүүлгийн эзлэх хувь зарим жилд 78.0 хувь (2020 он)-д хүрсэн байна. Урсгал шилжүүлгийн хэмжээ 2020 онд огцом нэмэгдсэн нь УИХ, Засгийн газрын тогтоолоор малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор

ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20,000 төгрөг буюу нийт 175.0 тэрбум төгрөгийн урамшууллыг малчин, мал бүхий иргэдэд мөнгөн шилжүүлэг хэлбэрээр олгосонтой холбоотой.

Хүснэгт 14. ХХААХҮ-ийн салбарын төсвийн урсгал зардлын бүтэц, /дүнд эзлэх хувиар/

Он	Бараа, үйлчилгээний зардал	Татаас ба шилжүүлэг	Татаас	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	Урсгал шилжүүлэг	Нийт з Урсгал зардал
2010	45.7%	54.3%	15.5%	15.5%	38.8%	37.9%
2011	71.1%	28.9%	28.6%	28.6%	0.3%	0.0%
2012	43.2%	56.8%	56.2%	56.2%	0.6%	0.0%
2013	44.1%	55.9%	54.9%	54.9%	1.1%	0.0%
2014	49.8%	50.2%	49.3%	49.3%	1.0%	0.0%
2015	40.1%	59.9%	59.0%	58.9%	0.9%	0.0%
2016	56.1%	43.9%	42.9%	42.9%	1.0%	0.2%
2017	45.1%	54.9%	53.6%	53.6%	1.3%	0.3%
2018	49.7%	50.3%	49.2%	49.2%	1.1%	0.3%
2019	58.7%	41.3%	39.9%	39.9%	1.4%	0.2%
2020	22.0%	78.0%	20.3%	19.9%	57.7%	57.0%
дундаж	47.8%	52.2%	42.7%	42.6%	9.6%	8.7%

Эх сурвалж: ХХААХҮЯ

Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар урамшуулал, дэмжлэг нь дотроо төрийн өмчит байгууллагад болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасаас бүрдэнэ. ХХААХҮ-ийн салбарын хувьд хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, урамшуулал дийлэнхийг бүрдүүлж байна. Энэхүү татаас нь арьс, шир, ноос, улаан буудай, сүүний урамшуулал хэлбэрээр олгосон хөрөнгөөс голлон бүрдэж байна.

ХХААХҮ-ийн салбарын төсвийн хувьд 2011-2019 онд шилжүүлгийн хэмжээ нь дунджаар урсгал зардлын 1.0 хувийг эзэлж байсан бол 2020 онд 57.7 хувийг эзэлсэн байна. Энэ нь 2020 онд нийт 175.0 тэрбум төгрөгийн ноолуурын урамшуулал олгосонтой холбоотой.

Үүнээс харахад тус салбарын урсгал зардалд татаас, шилжүүлэг хэлбэрээр олгох гарцын мөнгөн дэмжлэг өндөр хувь эзэлж байна.

4.3 УЛСЫН ТӨСВИЙН ТАТААС, ДЭМЖЛЭГИЙН ЗАРДАЛ

Өнгөрсөн хугацаанд ХАА-н салбарт улсын төсвөөс татаас, шилжүүлгээс гадна бусад олон төрлийн дэмжлэгийг үзүүлж ирсэн. ХАА-н салбарт 2010-2020 онд зарцуулсан улсын төсвийн нийт дэмжлэгийг Хүснэгт 15-аар харуулав.

Хүснэгт 15. ХАА-н салбарын нийт дэмжлэг, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
ХАА-н салбарын нийт татаас, дэмжлэг	35.3	69.2	98.7	95.6	93.9	51.4	96.7	112.6	88.9	86.4	264.8	1,093.3
1 Мал аж ахуй	14.7	49.2	59.6	59.4	57.3	41.9	77.8	101.5	64.8	59.0	238.2	823.4
1.1 Татаас, шилжүүлэг (мөнгөн)		9.9	29.4	29.7	30.7	26.7	43.1	38.4	39.0	35.5	214.2	496.4
1.2 Мөнгөн бус дэмжлэг	14.7	39.4	30.1	29.7	26.6	15.2	34.6	63.1	25.8	23.5	24.0	326.9
1.2.1 Мал аж ахуйг дэмжсэн арга хэмжээ	9.0	19.7	9.5	14.7	13.5	3.6	4.5	42.7	1.6	3.4	3.2	125.4
1.2.2 Мал эмнэлгийн үйлчилгээ	5.7	19.7	20.6	15.1	13.1	11.6	30.1	20.5	24.2	20.1	20.9	201.5
2 Газар тариалан	20.6	19.9	39.2	36.1	36.6	9.5	18.9	11.1	24.1	27.3	26.6	269.9
2.1 Татаас (мөнгөн)	10.9	14.5	27.8	25.3	24.7	5.6	15.0	7.9	12.9	22.4	22.7	189.7
2.2 Мөнгөн бус дэмжлэг	9.7	5.5	11.3	10.8	11.8	3.9	4.0	3.3	11.1	4.9	3.9	80.1

Эх сурвалж: ХХААХҮЯ

Дээрх хүснэгтээс харахад ХАА-н салбарт 2010-2020 онд нийт 1 их наяд 93.3 тэрбум төгрөгийн, дэмжлэгийг улсын төсвөөс үзүүлсэн байх бөгөөд үүний 75.3 хувь буюу 823.4 тэрбум төгрөгийг МАА-н салбарт, 24.7 хувь буюу 269.9 тэрбум төгрөгийг газар тариалангийн салбарт тус тус зарцуулсан байна.

ХАА-н салбарын нийт дэмжлэгийн 62.8 хувь буюу 686.2 тэрбум төгрөг нь мөнгөн хэлбэрийн, 37.2 хувь буюу 407.1 тэрбум төгрөгийн мөнгөн бус дэмжлэг байна.

Мөнгөн хэлбэрийн дэмжлэгт ноос, арьс шир, мах, сүү, ноолуур, улаан буудайн мөнгөн урамшуулал болон хүүгийн хөнгөлөлт хамрагдаж байна.

Олон улсад түгээмэл ашигладаг ЭЗХХАБ-ын аргачлалын дагуу мөнгөн бус дэмжлэгт дараах арга хэмжээг хамруулсан болно. Үүнд:

- > ХАА-н хоршоодод болон мал эмнэлгийн нэгжид зээлийн дэмжлэг үзүүлэх;
- > Малд үзлэг ангилалт хийх, хээлтүүлэгч мал шинээр нөхөн тавих баталгаажуулах;
- > Мал бүртгэлжүүлэх арга хэмжээ;

- > Бэлчээр хадлангийн талбайг сайжруулж, тэжээлийн ургамал тариалах иргэн, ААН-д үзүүлэх дэмжлэг;
- > Хадлан тэжээл үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмж худалдан авч иргэн, ААН-д хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох;
- > Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг шинээр гаргах;
- > Бэлчээрийн ургамал хамгаалал /үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээ/;
- > Эрчимжсэн МАА-г дэмжих хөнгөлөлттэй зээл;
- > Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх;
- > Мал эмнэлгийн үйлчилгээ;
 - Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
 - Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
 - Архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
 - Ариутгал, халдваргүйжүүлэлт;
- > Газар тариалангийн салбарт үзүүлсэн дараах дэмжлэг;
 - Түлш, шатахууны хөнгөлөлттэй зээл;
 - Бордоо;
 - Тоног, төхөөрөмжийн зээл;
 - Үрийн буудайн дэмжлэг;
 - Ургамал хамгааллын бодис;
 - Усалгаатай тариаланг дэмжих арга хэмжээ;
 - Хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн дэмжлэг;
 - Жимс, жимсгэнийн аж ахуйн дэмжлэг зэрэг болно.

2010-2020 онд олгосон мөнгөн дэмжлэгийг нэр, төрлөөр нь доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 16. ХАА-н салбарын мөнгөн дэмжлэг /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Улаан буудайн урамшуулал	10.9	14.5	27.8	25.3	24.7	5.6	15.0	7.9	12.9	22.4	22.7	189.7
Ноосны урамшуулал		9.9	29.4	18.3	18.3	18.3	19.4	22.6	22.5	18.6	19.4	196.6
Арьс, ширний урамшуулал					2.9	8.4	9.3	13.0	11.8	12.3	9.9	67.5
Сүүний урамшуулал											1.0	1.0
Нөөцийн мах бэлтгэлийн урамшуулал				11.4	9.5		14.5					35.4
Нөөцийн мах бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлт								2.7	4.7	4.7	3.8	15.9

Ноолуурын урамшуулал											174.9	174.9
Ноолуур бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлт											5.1	5.1
Нийт	10.9	24.3	57.2	55.0	55.4	32.2	58.1	46.2	51.9	57.9	236.9	686.2

Эх сурвалж: ХХААХҮЯ

Анх 2007 онд улаан буудайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүн амын хэрэгцээг дотоодын улаан буудайгаар үйлдвэрлэсэн гурилаар хангах зорилтын хүрээнд зохих шаардлага хангасан иргэд, ААН-ийн хураан авсан улаан буудайн тонн тутамд 80.0 мянган төгрөгийн урамшууллыг улсын төсвөөс олгож эхэлсэн байна. Түүнчлэн 2011 оноос ноос, 2013 оноос нөөцийн мах бэлтгэл, 2014 оноос арьс, шир, 2020 оноос сүүний үйлдвэрлэлд тус тус урамшуулал улсын төсвөөс олгож эхэлжээ. Мөн 2020 онд малчид, мал бүхий иргэдэд бэлтгэсэн ноолуурын кг тутамд 20.0 мянган төгрөгийн урамшууллыг улсын төсвөөс мөнгөн шилжүүлэг хэлбэрээр олгосон байна.

ХАА-н бүтээгдэхүүнд олгосон урамшууллыг тухайн түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн буюу бэлтгэсэн жилд нь багтаан улсын төсвөөс олгож байсан бол 2014 оноос эхлэн дараа оны төсөвт суулгаж, санхүүжүүлж ирсэн байна.

Дээр дурдсан нэр, төрлийн ХАА-н бүтээгдэхүүний мөнгөн урамшуулалд 2010-2020 оны хугацаанд улсын төсвөөс нийт 686.2 тэрбум төгрөгийн урамшуулал, дэмжлэг /цаашид урамшуулал, дэмжлэг гэх/ олгосон байна.

Хүснэгт 17. ХАА-н бүтээгдэхүүнд олгосон мөнгөн урамшууллын төсвийн зардалд эзлэх хувийн жин

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд	0.4%	0.5%	1.0%	0.9%	0.8%	0.5%	0.6%	0.5%	0.6%	0.5%	1.6%	0.7%
Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд	0.5%	0.7%	1.3%	1.2%	1.1%	0.6%	0.8%	0.6%	0.7%	0.6%	2.0%	0.9%
ХХААХҮ-ийн салбарын нийт зарлага ба цэвэр зээлд	8.4%	4.7%	31.7%	30.9%	41.1%	56.2%	40.9%	17.0%	30.1%	34.6%	68.1%	33.1%
ХХААХҮ-ийн салбарын урсгал зардалд	13.3%	26.4%	72.7%	58.9%	54.6%	35.9%	51.2%	46.5%	50.6%	47.6%	77.0%	48.6%

Дээрх хүснэгтээс харахад ХАА-н бүтээгдэхүүний зориулалттай дэмжлэг нь 2010-2020 оны дунджаар авч үзэхэд Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 0.7 хувь, улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 0.9 хувь, ХХААХҮ-ийн салбарын улсын төсвийн нийт зарлагын 33.1 хувь, ХХААХҮ-ийн салбарын улсын төсвийн урсгал зардлын 48.6 хувийг тус тус эзэлж байна.

Өөрөөр хэлбэл, ХАА-н бүтээгдэхүүнд мөнгөн хэлбэрээр олгож буй дэмжлэг нь салбарын төсвийн ихээхэн хувийг эзлэх болсон байна. ХАА-н салбарт олгосон дэмжлэгийн зорилго, хэрэгжилтийн талаар түүхий эд тус бүрээр нь авч үзье.

УЛААН БУУДАЙН УРАМШУУЛАЛ

ХАА-н мөнгөн татаасыг тухайн бүтээгдэхүүн олгож буй урамшуулал хэмээн нэрлэж ирсэн бөгөөд анх 2007 оноос буудайн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улаан буудай үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдэд олгож эхэлсэн байна. Уг шийдвэрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд үндэслэн Засгийн газрын тогтоолоор гаргасан бөгөөд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан олгохоор заасан байна. Тариалангийн тухай хуульд 2009 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн улсад болон гурилын үйлдвэрт нийлүүлсэн буудайн тонн тутамд мөнгөн урамшуулал тооцон олгож болохыг хуульчилсан байна.

Тариалангийн тухай хуулийг шинэчлэн найруулж 2016 онд УИХ-аас батлан гаргасан бөгөөд хуулийн 19.1-д “Тариалангийн үйлдвэрлэлд төрөөс мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг үзүүлж болно” гэж мөн заасан.

Тариалангийн тухай хуульд буудайн тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг Засгийн газар тогтоохоор, холбогдох журмыг тариалангийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан байна. Энэ хүрээнд ХХААХҮ-ийн сайдын тушаалаар урамшуулалд хамрагдах ААН, иргэдийн жагсаалт, урамшууллын хэмжээг баталж, олгож иржээ.

Өнгөрсөн хугацаанд тухайн жилийн төсвийн боломжийг харгалзан улаан буудайн 1 тонн тутамд 45.0-150.0 төгрөгийн урамшууллыг олгох шийдвэр гаргасан байна /Хүснэгт 18 /.

Хүснэгт 18. Улаан буудайн 1 тонн тутамд олгох урамшууллын тогтоосон хэмжээ

	Засгийн газрын тогтоол гарсан огноо	Засгийн газрын тогтоолын дугаар	1 тонн тутамд олгох урамшууллын хэмжээ /төг-өөр/
1	2007.09.19	227	60,000
2	2008.12.03	47	80,000
3	2009.11.25	350	50,000
4	2012.10.06	77	100,000
5	2013.11.09	366	150,000
6	2015.01.26	31	70,000
7	2016.04.11	202	50,000
8	2017.02.22	62	50,000-60,000
9	2018.02.06	48	50,000-60,000
10	2019.01.23	44	45,000
11	2020.01.08	15	55,000-100,000

Эх сурвалж: <https://legalinfo.mn>

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 350 дугаар тогтоолыг үндэслэн ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 24/34 тоот тушаалаар “Хүнсний буудайнд мөнгөн урамшуулал олгоход баримтлах журам”-ыг анх баталсан байна.

ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2019 оны 290/А-504 тоот тушаалаар “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд одоо энэхүү журмын дагуу улаан буудайн урамшуулыг олгож байна.

Мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх зорилгыг уг журамд “...хүн амыг эх орны үйлдвэрийн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах...” гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл улаан буудайн мөнгөн урамшууллын зорилго нь улаан буудай, түүгээр хийсэн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэж байна гэж үзэж болно. Тариалангийн тухай хууль болон дээрх журамд мөнгөн дэмжлэгт хамрагдахад дараах гол шалгуур үзүүлэлтийг харгалзахаар заажээ. Үүнд:

- техник, технологийн шинэчлэл хийсэн
- хөрсний үржил шимийн хэвийн байдлыг хадгалсан
- ургацын чанарыг тогтвортой дээшлүүлсэн
- орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байдал

Улаан буудайн урамшуулалд 2007 оноос 2020 оныг дуустал улсын төсвөөс татаас хэлбэрээр нийт 215.4 тэрбум төгрөг олгосон байна. Улаан буудайн урамшууллын талаарх мэдээллийг Хүснэгт 19-д харуулав.


Хүснэгт 19. Улаан буудайн урамшууллын мэдээ

Он	Тариалсан талбай, мян.га	Хураан авсан улаан буудай, мян.тн	Олгосон урамшууллын дүн, сая.төг	Урамшуулалд хамрагдсан буудайн хэмжээ, мян.тн	1 тн -д олгосон урамшуулал, мян. төг
2007	116.1	109	3,953	65.9	60.0
2008	154	201	11,164	139.6	80.0
2009	252	389	10,500	210.0	50.0
2010	251	346	10,906	218.1	50.0
2011	285	438	14,471	289.4	50.0
2012	296	462	27,829	278.3	100.0
2013	275	370	25,321	248.9	101.7
2014	290	489	24,727	349.9	70.7
2015	362	204	5,591	111.8	50.0
2016	355	467	14,962	292.5	51.2
2017	367.2	231	7,873	128.0	61.5
2018	343.9	436	12,930	281.2	46.0
2019	339.1	411	22,421	242.3	92.5
2020	364.8	406	22,717	255.8	88.8

Эх сурвалж: ҮСХ, ХХААХҮЯ

ХХААХҮЯ-ны мэдээгээр 2007-2020 онд улаанбуудайн урамшууллыг жилд дунджаар 675 орчим иргэн, ААН авсан байна. Мөн энэ хугацаанд тухайн жилийн хураан авсан улаанбуудайн ургацын дунджаар 62.3 хувь нь урамшуулалд хамрагдсан байна.

Зураг 5. ХУРААН АВСАН НИЙТ УЛААН БУУДАЙ УРГАЦ БА УРАМШУУЛАЛД ХАМРАГДСАН УЛААН БУУДАЙН ХЭМЖЭЭ




Эх сурвалж: ХХААХҮЯ

Улаан буудайн урамшууллын харилцааг зохицуулсан журмын 3.2-д “Мөнгөн урамшуулалд хамруулах тухай Сайдын шийдвэрийг үндэслэн стратегийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн гурил үйлдвэрлэх зорилгоор нийлүүлсэн улаан буудайн нэгж хэмжээнд урамшуулал олгоно.” гэж зааснаас үзэхэд урамшуулал олгох зорилго нь хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын нийлүүлэлтийг нэмэгдүүлж, дотоодоос хангахад чиглэгдэж байгаа бөгөөд дээрх зургаас харахад дотоод хангамжийн хувь нэмэгдэж 2017 оныг эс тооцвол гурилын гол түүхий улаан буудайг дотоодоос бараг 100 хувь хангаж ирсэн байна.

Улаан буудайн дотоодын нийлүүлэлт нэмэгдэж байгаа нь зөвхөн ганц урамшууллын нөлөө биш өөр олон хүчин зүйлс нөлөөлснийг тэмдэглэх нь зүйтэй. Засгийн газраас тариаланчдад үзүүлсэн түлш, шатахуун, бордоо, техник тоног, төхөөрөмж, үр, хөнгөлөлттэй зээл үүнд хамрагдана.

Улаан буудайгаар үйлдвэрлэдэг гурилын дотоодын хангамжийн хувь 2010-2012 онд 60-70 хувь байсан бол аажмаар нэмэгдэж сүүлийн 5 жилд бараг 100 хувьд хүрсэн байна. Энэ нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр төсвөөс олгож ирсэн улаанбуудайн урамшуулал болон бусад олон төрлийн дэмжлэгийн үр нөлөө юм.

**Зураг 6. ДОТООДОД ҮЙЛДВЭРЛЭЖ НИЙЛҮҮЛСЭН ГУРИЛЫН ХАНГАМЖИЙН ХУВЬ
ОЛОН УРАМШУУЛАЛД ХАМРАГДСАН УЛААН БУУДАЙН ХЭМЖЭЭ**



Эх сурвалж: ҮСХ

Засгийн газраас ихээхэн дэмжлэг үзүүлж улаан буудайн нийт үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж буй нь хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдалд тустай боловч урт хугацаанд хөрсний үржил шим, чанар, байгаль орчинд хэрхэн нөлөөлж, ямар өөрчлөлт гарч байгааг судлах шаардлагатай. Өөрөөр хэлбэл Засгийн газрын дэмжлэг нь тогтвортой газар тариалан (sustainable agriculture practices- SAP)-г хөгжүүлэхэд чиглэгдэх учиртай. Зөвхөн үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах нь байгаль орчинд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй ч хөрсний үржил шим муудсанаар урт хугацаанд эргээд нэгжийн ургац, нийт үйлдвэрлэлийн хэмжээг бууруулах, цөлжилтийг даамжруулах аюул бий.

Тогтвортой газар тариалан нь байгалийн нөөцийг хамгаалах, хөрсийг доройтуулахгүй байх, эдийн засгийн үр ашигтай, нийгэмд хүлээн зөвшөөрөхүйц, зүй зохистой технологи ашиглахтай холбоотой цогц асуудал юм.

Б.Пунцагдорж, Д.Оросоо, Шуеши Хуо, Шианли Шиа нар улаан буудайн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг нь тогтвортой газар тариалан эрхлэхэд ямар нөлөө үзүүлж буйг 9 аймгийн 840 тариаланчдын зан төлөв дээр үндэслэн судалж үзсэн байна⁷. Уг судалгааны дүгнэлтэд "...улаан буудайн тариаланчдад олгож буй татаас нь тогтвортой хөдөө аж ахуйн туршлагыг нэвтрүүлэхэд төдийлөн нөлөө үзүүлэхгүй байна. Энэ нь хөдөө аж ахуйг тогтвортой хөгжүүлэхийн тулд өнөөгийн татаасын бодлогод өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг харуулж байна" гэж дүгнэсэн байна. Мөн уг судлаачид тогтвортой газар тариаланг хөгжүүлэхэд төрийн дэмжлэг болон хөрсний доройтлын талаарх тариаланчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх ажлыг хослон хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой болохыг тэмдэглэсэн байна.

7-B.Puntsagdorj, D.Orosoo, Xuexi Huo, and Xianli Xia, "Farmer's Perception, Agricultural Subsidies, and Adoption of Sustainable Agricultural Practices: A Case from Mongolia. Sustainability 2021, 13, 1524. <https://doi.org/10.3390/su13031524>

2010 онд Дарханы Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн (УГТЭШХ)-гээс газар тариалан эрхэлдэг бүс нутгийн тариалангийн талбайн хөрсний агрохимийн картограммын судалгаагаар бүх талбай эвдрэлд орсон, үүнээс 26.1 мянган га буюу 4,5% сул, 202.2 мянган га буюу 34,9% дунд зэрэг, 351.0 мянган га буюу 60,6% хүчтэй эвдрэлтэй гэж гаргасан байна. (Н.Нямсамбуу, Д.Ихбаяр нар)

Мөнгөн урамшуулал олгох журамд хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, элэгдэл эвдрэлийг бууруулах, газар тариалангийн бусад зохистой дадал хэрэгжүүлсэн байх шаардлагуудыг тавьсан байгаа боловч түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, мониторинг, үнэлгээ хэрхэн хийж байгаа нь тодорхойгүй байна.

Журмын 8-р зүйлд улаан буудайн урамшууллын хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хяналт, шалгалт хийхээр зохицуулжээ. Цаашид хяналт-шинжилгээ, мониторингийг хэрхэн, ямар цаг хугацаанд хийх талаар нарийвчилсан аргачлал, зохицуулалт оруулж, жил бүр үнэлгээ хийж, бодлого ба түүний хэрэгжилтийг тогтмол сайжруулж байх нь зүйтэй.

НООСНЫ УРАМШУУЛАЛ

УИХ-ын 2011 оны 30-р тогтоолоор үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж, ноос боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан ноосыг малын ашиг шим, үүлдэрлэг байдал, ноосны чанараас хамааруулан хонь, тэмээний ноосны килограмм тутамд 1,000-2,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн байна.

Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газрын 2011 оны 221 дүгээр тогтоолоор анх баталсан бөгөөд үүнээс хойш хэд хэдэн удаа шинэчлэн батлан мөрдөж ирсэн байна.

Хамгийн сүүлд Засгийн газрын 2019 оны 343-р тогтоолоор журмыг шинэчлэн баталсан. Үүнд ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэр, цех-д хонь, тэмээний ноос бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээд, өмчийн бүх хэлбэрийн цөм сүргийн аж ахуйд мөнгөн урамшуулал олгохоор заажээ.

Энэхүү журамд зааснаар боловсруулах үйлдвэрт ноос бэлтгэж тушаасан малчинд өмнөх жилийн эцсийн мал тооллогын А данс дах малын тоо, үүлдэрлэг байдал, ашиг шим, ноосны чанараас хамааран ноосны кг тутамд 1,500-2,000 төгрөгийн урамшуулал олгож байна. Ингэхдээ тухайн жилийн төсөв, санхүүгийн боломжийг харгалзан нэг кг ноосонд олгох урамшууллын хэмжээг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар шийдвэрлэж байна.

Ноосны урамшууллыг 2011 оноос олгож эхлэхдээ тухайн онд бэлтгэсэн ноосны урамшууллыг онд нь багтаан ХХААХҮ-ийн сайдын тушаалаар олгож байсан бол 2014 оноос эхлэн өмнөх онд бэлтгэсэн ноосонд дараагийн жилд нь урамшууллыг олгохоор шийдвэрлэж, санхүүжүүлж ирсэн байна.

Доорх хүснэгтэд ноосны урамшууллыг ноос бэлтгэсэн жилтэй нь харгалзуулан харууллаа. Жишээ нь 2020 онд бэлтгэсэн 19.7 мянган тонн ноосонд зориулан 2021 онд 32.4 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон байх бөгөөд доорх хүснэгтэд урамшууллын хэмжээг харгалзах 2020 онд зэрэгцүүлж харуулсан болно.

Хүснэгт 20. Ноосны урамшуулал болон бэлтгэсэн ноосны хэмжээ


Он	Нийт малчдын тоо	Бэлтгэсэн ноосны хэмжээ (тонн)	Ноосны урамшуулалд хамрагдсан малчдын тоо	Урамшуулалд хамрагдсан ноосны хэмжээ (тонн)	Урамшууллын хэмжээ (сая төг.)	1 малчинд олгосон урамшууллын дундаж хэмжээ (сая төг)
2010	327,154	17,117.7				
2011	311,185	16,166.2	32,977	3,126.8	9,862.0	299.1
2012	289,646	17,486.9	103,162	14,235.9	29,414.3	285.1
2013	285,691	20,229.2	117,667	18,307.3	36,614.7	311.2
2014	293,620	22,318.7	88,386	18,427.5	18,427.5	208.5
2015	297,828	25,820.8	79,500	17,544.6	19,350.9	243.4
2016	311,373	27,399.8	92,885	20,598.9	22,637.2	243.7
2017	303,590	30,626.5	86,465	20,111.9	22,408.7	259.2
2018	288,700	33,013.4	70,752	16,614.0	18,599.9	262.9
2019	285,482	33,692.0	46,828	13,200.0	19,419.5	414.7
2020	298,789	35,565.9	93,969	19,737.5	32,367.7	344.5
Дундаж	299,369	25,403.8	81,259	16,190.4	22,549.3	287.2

Эх сурвалж: ҮСХ, ХХААХҮЯ

Дээрх Хүснэгт 20-д үзүүлснээр 2011-2020 онд ноосны урамшуулалд улсын төсвөөс нийт 225.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Жилд дунджаар 22.5 тэрбум төгрөгийг ноосны урамшуулалд олгожээ. Энэ хугацаанд жилд дунджаар 81.3 мянган малчин, мал бүхий иргэн ноосны урамшуулал авч, 16.2 мянган тонн ноос бэлтгэж, дотоодын үйлдвэрт нийлүүлсэн байна.

Ноосны урамшууллыг анх олгосон 2011 онд нийт малчдын 10.6 хувь нь урамшуулалд хамрагдсан бол 2013 онд хамгийн их буюу нийт малчдын 90 хувь нь хамрагджээ. Урамшуулалд хамрагдсан нэг малчин жилд дунджаар 287.2 мянган төгрөгийн ноосны урамшуулал авсан тооцоо гарч байна. 2011-2020 оны дунжийг авч үзвэл нийт малчдын 62.8 хувь, нийт бэлтгэсэн ноосны 27.5 хувь нь урамшуулалд хамрагдсан байна /Зураг 7/.

Зураг 7. НООСНЫ УРАМШУУЛАЛД ХАМРАГДАЛТЫН ХУВЬ




Эх сурвалж: YCX, ХХААХУЯ, судлаачдын тооцоо

Дээрх зургаас харахад ноосны урамшууллыг олгож эхэлсэн 2011 оноос хойш улсын хэмжээнд бэлтгэсэн нийт ноосны хэмжээ жил бүр нэмэгдэж ирсэн байна. Тухайлбал, 2011 онд улсын хэмжээнд 16.2 мянган тонн хонины ноос бэлтгэж байсан бол 2020 онд 35.6 мянган тонн ноос бэлтгэжээ.

Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу 2011-2013 онд хонины ноосны кг тутамд дунджаар 2,000 төгрөг олгож байсан бол 2014-2018 онд кг тутамд 1,000 төгрөг олгож иржээ. 2019 оны 343-р тогтоолоор шинэчлэн баталсан “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-д зааснаар нарийн, нарийвтар болон тодорхой бүс нутагт үржүүлж буй бүдүүвтэр хонины ноос, тэмээний эм ноосны кг тутамд 2,000 төгрөг, бусад бүс нутагт үржүүлж байгаа хонины ноосны кг тутамд 1,500 төгрөгийн урамшуулал олгож эхэлсэн. 2019 оноос хонь, тэмээний ноосны кг тутамд дунджаар 1,600 төгрөгийн урамшуулал олгож байна.

Улсын хэмжээгээр 2010 оноос хойш жил тутамд бэлтгэсэн нийт ноосны дийлэнх буюу 93-96 хувийг хонины ноос, 4-7 хувийг тэмээний ноос эзэлж байна. Зураг 8-д үзүүлсэн хонь, тэмээний ноосны зах зээлийн дундаж үнийг бэлтгэсэн ноосны энэхүү харьцаагаар жигнэж гаргасан болно.

Зураг 8. НООСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ БОЛОН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ



Эх сурвалж: ҮСХ, ХХААХЯ, судлаачдын тооцоо

Хонины 1 кг ноосны зэх зээлийн үнэ 2010-2016 онд 420-550 төгрөг байсан бол 2017 онд 1,720 төгрөг, 2018 онд 2,890 төгрөгт хүрснээ 2019 онд буурч 600 төгрөг болсон байна.


Тэмээний 1 кг ноосны зах зээлийн үнэ 2010-2017 онд 2,600-4,700 орчим төгрөг байсан бол 2018 онд огцом өсөж 9,800 төгрөгт хүрсэн байна. Харин 2019 онд эргээд буурч 4,100 төгрөг, 2020 онд 3,890 төгрөгийн ханштай байжээ.

Дээрх Зураг 8-аас харахад ноосны кг тутамд олгож буй урамшууллын хэмжээ болон ноосны зах зээлийн үнийн хооронд ямар нэг хамаарал ажиглагдахгүй байгаа бөгөөд ноосны үнэ бусад хүчин зүйлсээс хамааран хэлбэлзэж байна.

Ноосны урамшууллыг малчдад мөнгөн хэлбэрээр шууд олгож байгаа бөгөөд урамшуулал нь ноосны үнэд төдийлөн нөлөөлөхгүй, ноосны борлуулалтаас олох малчдын орлого урамшуулал хамаарахгүй болохыг үүнээс харж болно. ҮСХ-аас гаргадаг өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-нд өрхийн орлогыг хөдөлмөр эрхлэлтийн хэлбэрээр буюу малчин болон мал бүхий иргэн гэж ангилж гаргадаггүй учир малчин өрхийн орлогод ХАА-н мөнгөн урамшуулал ямар нөлөөтэй байгааг нарийвчлан тодорхойлох боломжгүй байна.

ӨНЭЗС-нд өрхүүдийг суурьшлаар нь Улаанбаатар, Аймгийн төв, Сумын төв, Хөдөө гэж ангилж үзсэн байна. Хэрэв "хөдөө" гэсэн ангилалд малчин болон мал бүхий иргэн хамрагдана гэж үзвэл тэдгээр өрхийн мөнгөн орлогын бүтцийг Зураг 9-р үзүүлэв.

Зураг 9. ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, /ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР/



Эх сурвалж: УСГ, ӨНЭЗС 2018-2021

Дээрх Зураг 9-аас харахад 2018-2021 оны дунджаар хөдөөгийн малчин өрхийн сарын мөнгөн орлого 959.8 мянган төгрөг байна. Малчин өрхийн мөнгөн орлогын бүтцийг авч үзвэл 56.3 хувь нь ХАА-н үйлдвэрлэлийн орлого, 24.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, 12.7 хувь нь цалин, хөлс, 5.3 хувь нь ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 1.1 хувь нь бусад орлого байна.

ӨНЭЗС-нд мөнгөн орлогын бүтцэд ХАА-н урамшуулал аль орлогод хамаарах нь тодорхойгүй байна. Урамшуулалд хамрагдсан нэг малчин жилд дунджаар 287.2 мянган төгрөгийн ноосны мөнгөн урамшуулал авдаг гэж үзвэл 1 сард ногдох нь 23.9 мянган төгрөг болж байна. Энэ нь малчны сарын дундаж мөнгөн орлогын 2.5 хувийг эзлэхээр байна.

Ноосны урамшуулал нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нөлөө үзүүлж буй эсэхийг шинжилж үзэхийн тулд ноосны урамшуулал болон ноосоор хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хамаарлыг доорх хүснэгт, зургаар үзүүлэв.


Хүснэгт 21 . Ноосны урамшуулал, ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Урамшууллын дүн / тэрбум төг./	9.9	29.4	18.3	18.3	18.3	19.4	22.6	22.5	18.6	19.4
Урамшуулалд хамрагдсан малчдын тоо /мян.хүн/	33.0	103.2	116.7	84.6	80.6	79.5	92.9	86.9	70.8	46.8
Хивс /мян.м2/	871.7	919.3	857.5	725.4	678.4	449.8	465.0	499.0	448.3	145.7
Нэхмэл /мян.ш/	40.2	48.7	53.8	58.3	70.1	63.5	52.9	70.7	14.2	13.9
Сүлжмэл /мян.ш/	45.8	79.9	170.9	202.6	316.8	424.9	310.0	92.7	45.4	41.5
Ээрмэл /мян.тн/	1.4	2.7	2.8	2.3	2.3	1.4	0.8	0.9	0.2	0.2
Эсгий /мян.м/	677.7	1,040.5	1072.0	1,502.3	1502.3	1,230.3	1,360.9	1398.1	1413.2	1621.0
Эсгий эдлэл /мян.ш/	147.3	198.3	209.4	174.1	105.6	151.6	125.0	49.2	64.7	0.9

Угаасан ноос /тн/	4,116.8	6,967.8	4,392.5	4,301.9	4,198.5	6,677	1,563	1,613.8	173.3	800
Самнасан ноос /тн/	82.7	586.4	725.3	504.9	710.1	803.7	1,264.6	424.3	557.5	337.7

Эх сурвалж: ХХААХҮЯ

Зураг 10. НООСНЫ УРАМШУУЛАЛ БОЛОН УРАМШУУЛАЛД ХАМРАГДСАН МАЛЧДЫН ТОО, БЭЛТГЭСЭН НИЙЛҮҮЛСЭН НООС, НООСОН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭМЖЭЭНИЙ ХАМААРАЛ



Эх сурвалж: ХХААХҮЯ

Дээрх Зураг 10-аас үзэхэд ноосны урамшууллын дүн болон түүнд хамрагдсан малчдын тоо 42%, бэлтгэн нийлүүлсэн ноосны хэмжээ 27%-ийн тус тус хамааралтай байна. Харин ноосоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ноосны урамшууллын хэмжээ төдийлөн нөлөөлөөгүй буюу 8.0 хувиас бага хамааралтай байна.

Ноосны урамшуулалд олгосон санхүүжилт нь малчдын тоо, ноос бэлтгэлийн хэмжээнд тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлсэн боловч ноосоор хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд төдийлөн нөлөө үзүүлээгүй нь дээрх шинжилгээнээс харагдаж байна. Энэ нь үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх урамшууллын гол зорилго төдийлөн хангагдаагүйг харуулж байна.

НӨӨЦИЙН МАХ БЭЛТГЭЛД ЗОРИУЛСАН УРАМШУУЛАЛ БОЛОН ХҮҮГИЙН ХӨНГӨЛӨЛТ

Монгол Улсад бэлчээрийн мал аж ахуй болон цаг уурын улирлын онцлогоос хамааран хавар 3-5 дугаар сард махны нийлүүлэлтийн улирлын шинж чанартай хомсдол бий болдог.

Бэлчээрийн мал аж ахуйн онцлог нь зун, намрын цагт мал тарга хүчээ авч, махны нийлүүлэлт нэмэгддэг бол 2-5 сард буюу өвлийн сүүл, хаврын улиралд мал турсан үед махны нийлүүлэлт эрс буурдаг давтамжтай. Нөгөө талаас, улирлын онцлогоос хамааран цаг уур хүйтрэх үед өвлийн мах бэлтгэл эхэлж, 11-12 дугаар сард махны нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг.

Хүнсний тухай хуулийн 6.1-д “Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний⁸ улирлын нөөцийг бүрдүүлнэ.” хэмээн заасан. Хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх, махны нийлүүлэлт, үнийн улирлын хэлбэлзлийг зохицуулах үүднээс Засгийн газрын 2005 оны 211 дүгээр тогтоолоор “Махны нөөц бүрдүүлж, борлуулсан аж ахуйн нэгжид урамшуулал олгох” журмыг батлан, анх нийслэлийн хүн амын 2006 оны хавар, зуны хэрэгцээнд мах бэлтгэн нөөцөлж, борлуулсан ба түүнээс хойш махны нөөц бэлтгэх энэхүү бодлогыг хэрэгжүүлж ирсэн байна.

Нөөцийн мах бэлтгэлд зориулсан дэмжлэгийг 2010-2012 онд улсын төсвөөс гаргаагүй байх бөгөөд 2013-2016 он хүртэл нөөцийн мах бэлтгэлд урамшуулал олгосон байна. 2017-2020 онд нөөцийн мах бэлтгэсэн ААН-үүдэд зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

Хүснэгт 22. Нөөцийн мах бэлтгэлд зориулсан урамшуулал, /сая төгрөг/

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Нөөцийн мах бэлтгэлийн урамшуулал	11,399.5	9,500	14,500	14,496.6	2,733.6	4,656.1	4,660.8	3,846.1
Нөөцийн мах бэлтгэлийн урамшуулал	11,399.5	9,500	14,500	14,496.6				
Нөөцийн мах бэлтгэлийн зээлийн хүүгийн хөнгөлөлт					2,733.6	4,656.1	4,660.8	3,846.1

Эх сурвалж: ХХААХҮЯ

Нөөцийн мах бэлтгэлд 2013-2016 онд жил бүр 9.5-14.5 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон бол 2017-2020 онд зээлийн хүүгийн хөнгөлөлтөд жилд 2.7-4.6 тэрбум төгрөгийг ААН-үүдэд хүүгийн татаас хэлбэрээр олгожээ.

Улс орнууд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах зорилтыг хангах бодлогын нэг хэрэгсэл болгон хүнсний нөөц бүрдүүлдэг. Хүнсний нөөц бүрдүүлэх шаардлага дараах хоёр хүчин зүйлээс голчлон шалтгаалдаг байна. Үүнд:

1. ХҮН АМЫН ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТҮВШИН
2. ХҮН АМЫН ОРОН ЗАЙН БАЙРШИЛ

⁸ -Хүнсний тухай хууль, “3.1.6. “стратегийн хүнс” гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг” гэж заасан.

Монгол Улсын хувьд хэрэглээний барааны үнэнд нөлөөлдөг махны үнийг тогтворжуулах зорилгоор махны нөөц бүрдүүлж ирсэн. Махны нөөц бүрдүүлэх шалтгааныг дээрх хоёр хүчин зүйлээр тайлбарлахыг оролдъё. Үүнд:

1. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хэмжих⁹ дөрвөн үзүүлэлт болох хүнсний хангамж, хүнсний хүртээмж, хүнсний илчлэг, шим тэжээл, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг 2016-2020 оны байдлаар хүснэгт. харуулав. Үүнээс үзэхэд улсын хэмжээнд жишсэн нэг хүний мах махан бүтээгдэхүүний хангамж, хүртээмж өндөр хэмжээнд байна. Мах махан бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлын хувьд үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ төдийлөн нэмэгдээгүй байгаагаас үзэхэд аюулгүй байдал дээшлээгүй байна.

Хүснэгт 23. 2016-20 онд Монгол Улсын махны хэрэглээ, хангамжийн түвшин

Хүнсний бүтээгдэхүүн	2016*		2017		2018		2019		2020	
	Хэрэглээ	Хангамж	Хэрэглээ	Хангамж	Хэрэглээ	Хангамж	Хэрэглээ	Хангамж	Хэрэглээ	Хангамж
Малын мах	346.6	188.1	305.1	314.9	309.9	3385.8	450.1	397.7	629.4	546.4

Эх сурвалж: YCX

Мах, махан бүтээгдэхүүний хүртээмж, хангамж хангалттай учраас мах нөөц бүрдүүлэх шаардлагагүй гэж үзэхээр байна.

2. Монгол Улсын хүн амын 60 орчим хувьд нь нийслэл Улаанбаатар хотод төвлөрсөн. Мах махан бүтээгдэхүүн нийлүүлэх сүлжээний сул хөгжлөөс шалтгаалан мах махан бүтээгдэхүүний хангамжид улирлын чанартай доголдол, үүнээс улбаалсан махны үнийн огцом өөрчлөлт гардаг. Хангамжийн улирлын чанартай доголдлоос улбаалсан махны үнийн огцом өөрчлөлтийг сулруулах үүднээс нийслэл хотын иргэдийн махны хэрэгцээний зориулалтаар махны нөөц бүрдүүлдэг. Бусад улс орны туршлагаас үзэхэд онцгой тохиолдолд хүнсний нөөц бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн доголдол эсхүл хүнсний үнийн улирлын чанартай огцом өөрчлөлтийг даван туулж байна.¹⁰ Энэ нь манай улсад махны үнийн улирлын хэлбэлзлийг даван туулах үүднээс махны нөөц бүрдүүлж буй үндэслэлтэй төстэй байна. Улс орнуудын туршлагаас харахад энэ зорилгыг хангахын тулд хүнсний хомсдол буюу хямралд өртсөн өрхийг хүнсээр хангах замаар шийдэж байна. Манай улсын ашиглаж буй хүнсний нөөц бүрдүүлэхээр худалдан авалтын хэрэгслийг дараах хоёр гол зорилтыг хэрэгжүүлэхэд хөшүүрэг бий болгох үүднээс ашигладаг байна. Үүнд:

- i.** Нийт үйлдвэрлэгчид хүнсний үйлдвэрлэлд хөрөнгө оруулах болон өөрсдийн орлого нэмэгдүүлэх
- ii.** Зарим төрлийн үйлдвэрлэгчдэд хөдөөгийн ядуурлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн загварыг хөхүүлэх, зах зээлийн тусгайлсан хэрэгслийн хөгжүүлэлтийг дэмжих.

2013 онд Үндэсний аудитын газраас махны нөөц бүрдүүлэх арга хэмжээний үр дүнг хянаж, үнэлсэн байна. Энэхүү аудитын үнэлгээгээр дараах дүгнэлт хийжээ. Үүнд:

⁹ Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд (2015-2020 он) YCF

¹⁰ European Commission (2018) Using food reserves to enhance food and nutrition security in developing countries. Case Studies. Brussels: Directorate-General for International Cooperation and Development.

1. Хүн амыг хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүнээр хангах, мах нөөцлөлтийн талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилт зорилтот хэмжээнд хүрээгүй байна.

Үндэслэл:

- Инфляц өмнөх оны мөн үеэс буурсан хэдий ч 2013 оны 3 дугаар сард инфляцад үзүүлэх махны үнийн нөлөөлөл 18.6 хувь байсан нь 5 дугаар сард 22.6 болж 4 пунктээр буюу 21.5 хувиар өссөн нь Засгийн газар, Монгол банкнаас хэрэгжүүлж буй Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмжигдэх инфляцыг нам түвшинд байлгах зорилт хангагдаагүйг харуулж байна.
- Мах бэлтгэн нөөцөлж борлуулах үйл ажиллагаанд төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийн талаар Дархан-Уул, Орхон аймаг, Нийслэлийн 9 дүүргийн 1,175 хэрэглэгчээс авсан судалгаа, санал асуулгад оролцогсдын 70.6 хувь дунд зэрэг, тааруухан, маш муу гэж үнэлжээ.

2. Хүн амыг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар тогтвортой хангах бодлого үгүйлэгдэж байна.

Үндэслэл:

- Бэлтгэн нийлүүлж байгаа махны чанарыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдагсдын таван хүн тутмын дөрөв нь чанарын шаардлага хангахгүй байна гэж хариулжээ.

Өнөөг хүртэл дээрх үнэлгээнээс өөр үнэлгээ хийгдээгүй байна.

Манай улсын махны нөөц бүрдүүлэх замаар улирлын чанартай махны хомсдол, үнийн огцом өөрчлөлтийг даван туулах нь олон улсад хэрэглэгдэг арга боловч хэрэглэж буй хэрэгсэл буюу махны нөөцийн худалдан авалт нь оновчтой бус гэж үзэж байна. Мах нөөц бэлтгэх худалдан авалтыг дунд болон урт хугацаанд махны үйлдвэрлэлийн дэмжих зорилгоор голчлон ашигладаг байна.

АРЬС, ШИРНИЙ УРАМШУУЛАЛ

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн УИХ-ын 2011 оны 30-р тогтоол, малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих чиглэлээрх УИХ-ын 2012 оны 74-р тогтоолоор арьс, ширний урамшуулал олгох асуудлыг Засгийн газарт зөвшөөрсөн байна. Тухайлбал, УИХ-ын 2012 оны 74-р тогтоолд дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгажээ. Үүнд:

- Малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд 3,000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15,000 төгрөгийн урамшуулал олгох.
- Малчин, мал бүхий этгээдэд олгох урамшуулалд шаардагдах хөрөнгийг 2013 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид мөнгөн урамшуулал болон үнэт цаасны хүүгийн зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх.
- Хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох болон малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох, түүнд хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Энэ дагуу Засгийн газрын 2013 оны 394-р тогтоолоор “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг батлан гаргасан байна.

Уг журмын 1.1-д “Арьс, ширийг гүн боловсруулах үндэсний үйлдвэр (цех, төв, цэг зэрэг)-т (цаашид “үйлдвэр” гэх) арьс, ширийг стандартын дагуу бэлтгэн тушаасан, малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд (цаашид “малчин, мал бүхий этгээд” гэх) мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна” гэсэн байх бөгөөд “Арьс, ширийг гүн боловсруулдаг үйлдвэр” гэдэгт арьс, ширийг хатаах боловсруулалт хийсний дараа элдэж зөөлрүүлэн гүйцэд боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэр хамаарахаар зохицуулжээ.

Арьс, ширний урамшууллыг 2013 оноос эхлэн олгож эхэлсэн бөгөөд үүнд 2013 онд 2.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн бол жил бүр нэмэгдэж 2014 онд 14.6 тэрбум төгрөгийг олгосон байна. Харин 2018, 2019 онуудад 9.4-9.9 тэрбум төгрөгийг, 2013-2019 онд нийт 67.1 тэрбум төгрөгийг арьс, ширний урамшуулалд олгосон байна.

Арьс ширний урамшууллын үнийн дүн, бэлтгэсэн арьс, шир болон түүний зах зээлийн үнийн талаарх мэдээллийг доорх Хүснэгт 24-д үзүүлэв.

Хүснэгт 24. Арьс, ширний урамшуулал, бэлтгэсэн арьс шир, зах зээлийн үнийн мэдээлэл


Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Малчдын тоо (мян.хүн)	327.2	311.2	289.7	285.7	293.6	297.8	311.4	303.6	288.7	285.5
Бэлтгэсэн арьс, ширний нийт хэмжээ (мян. ширхэг)	11,299.0	8,743.8	8,766.5	10,894.5	10,217.9	15,192.9	14,001.2	14,523.4	19,290.6	19,555.8
Арьс, шир бэлтгэхэд ашигласан нийт малын тоо (мян. толгой)	8,373.7	8,283.2	8,365.0	10,205.0	10,006.4	14,556.7	12,700.1	14,105.8	16,526.7	17,960.3
Арьс, ширний зах зээлийн дундаж үнэ (мян.төг)	5.3	10.8	12.3	9.8	7.6	4.7	2.6	4.2	3.5	1.9
Арьс, ширний урамшуулал авсан малчдын тоо (хүн)				29811	57620	45,061	64,255	77,995	39,263	37,825
Урамшуулалд хамрагдсан нийт арьс, ширний тоо (мян.ширхэг)				741.4	2,072.6	2,492.9	31,24.9	3,467.4	2,229.0	2,610.2
Нийт урамшууллын хэмжээ (сая төг)				2711.7	8,179.3	9,500.8	12,713.0	14,611.5	9,462.2	9,913.0
Нэгж арьс, ширэнд олгосон урамшууллын дундаж хэмжээ (мян.төг)				3.7	3.9	3.8	4.1	4.2	4.2	3.8

1 малчинд ногдох урамшууллын дундаж хэмжээ (мян.төг)	91.0	142.0	210.8	197.9	187.3	241.0	262.1
Урамшуулалд хамрагдсан арьс, ширний дүнд эзлэх хувь	7.3%	20.7%	17.1%	24.6%	24.6%	13.5%	14.5%
Арьс, ширний урамшуулал авсан малчдын дүнд эзлэх хувь	10.4%	19.6%	15.1%	20.6%	25.7%	13.6%	13.2%

Эх сурвалж: ҮСХ, ХХААХҮЯ, судлаачдын тооцоо

Дээрх хүснэгтэд үзүүлснээр 2013-2019 онуудад нийт малчдын 10.4-25.7 хувь буюу дунджаар 16.9 хувь нь арьс, ширний урамшуулалд хамрагдсан байна. Урамшуулалд хамрагдсан нэг малчинд энэ хугацаанд жил бүр 91.0-262.1 мянган төгрөгийн урамшуулал оногдож байна. Энэ нь өмнө тооцсон малчдын сарын дундаж мөнгөн орлого (959.8 мянган төгрөг)-ын 0.8-2.3 хувийг бүрдүүлсэн тооцоо гарч байна.

Зураг 11. АРЬС, ШИРНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ БА НЭГЖ АРЬС, ШИРЭНД ОЛГОСОН УРАМШУУЛЛЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ /МЯНГАН ТӨГРӨГ/




Дээрх Зураг 11-д арьс, ширний зах зээлийн дундаж үнэ, нэгж арьс, ширэнд олгосон урамшууллын дундаж хэмжээг тооцон харууллаа. Судалгааны зорилгоор арьс, ширний зах зээлийн дундаж үнийг бодын шир болон бог малын арьсны зах зээлийн дундаж үнийг бэлтгэсэн шир болон арьсны хувийн жингээр жигнэж тооцов (богийн арьс-0.91, бодын шир-0.09).

Дээрх зургаас харахад нэгж арьс, ширэнд дунджаар 3.7-4.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон байх бөгөөд урамшуулал олгосон хугацаанд арьс, ширний дундаж үнэ зах зээлд буурсан хандлагатай харагдаж байна.

Арьс, ширний урамшууллын хэмжээ болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хамаарлыг 2011-2020 оны байдлаар доор үзүүлэв.

Зураг 12. АРЬС, ШИРНИЙ УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ БОЛОН УРАМШУУЛЛААР БЭЛТГЭСЭН АРЬС, ШИР, УРАМШУУЛАЛД ХАМРАГДСАН МАЛЧДЫН ТОО, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХАМААРАЛ



■ Корреляцийн коэффициент R^2

■ Детерминацийн коэффициент r^2

Эх сурвалж: ХХААХҮЯ, ҮСХ

Дээрх зургаас харахад арьс, ширний урамшууллын хэмжээ болон урамшуулалд хамрагдсан малчдын тоо, урамшууллаар бэлтгэсэн арьс, ширний хэмжээнд хүчтэй хамаарал ажиглагдаж байна. Харин арьс, ширний урамшууллын хэмжээ нь үйлдвэрт боловсруулсан арьс, ширний тоо хэмжээтэй төдийлөн хамааралгүй болохыг корреляци болон детерминацын коэффициент хэлж байна. Өөрөөр хэлбэл, арьс, ширний урамшуулал нь дотоодын арьс, ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээнд төдийлөн үр нөлөө үзүүлэхгүй байна гэж үзэж болно.

Тиймээс мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арьс, ширний урамшууллын эцсийн зорилго төдийлөн хангагдахгүй байна гэж хэлж болохоор байна.

СҮҮНИЙ УРАМШУУЛАЛ

Хүнсний тухай хуулийн 8-р зүйлд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх, дэмжлэг, урамшууллын харилцааг зохицуулсан байх бөгөөд уг хуулийн 8.3-д “Мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгож болно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1, 8.3-т заасан үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, урамшууллын хэлбэр, тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална” гэж заажээ.

Энэ дагуу Засгийн газрын 2020 оны 130-р тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баталсан байна. Журамд тусгаснаар

өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар хуурай сүүний импортыг бууруулах, хүн амын ундны сүүний хэрэгцээг тогтвортой, хүртээмжтэй хангахад урамшууллын зорилго чиглэгдэж байна. Журмын дагуу зохих шаардлагыг хангасан сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү тушаасан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшууллыг тухайн оны 11 дүгээр сарын 1-нээс дараа оны 3 дугаар сарын 31-нийг дуустал хугацаанд 1 литр тутамд таван зуун төгрөгөөр тооцож олгохоор заасан байна.

Уг журмын 3.1-д сүүний урамшуулалд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг ХХААХҮЯ холбогдох тооцоо, судалгааг хийж шаардлагатай бусад материалын хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, батлуулахаар ерөнхий байдлаар тусгажээ.

Сүүний урамшууллыг 2019 оноос эхлэн олгож эхлэхээр улсын төсөвт тусгасан боловч 2019 онд олгогдоогүй бөгөөд 2020 онд 1.0 тэрбум төгрөгийг төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 970.0 сая төгрөгийн урамшуулал олгогдсон байна.

Сүүний урамшуулал нь хэрэгжиж эхлээд удаагүй байгаа тул түүний үр нөлөө, үр дүнгийн талаар дүгнэлт хийх нь эрт ба бусад урамшууллын нэгэн адил хэрэгжилтийн байдалд жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн бодлого, хэрэгжилтийг сайжруулахад ашиглах нь зүйтэй. Үүний тулд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нарийвчилсан, аргачлал, зааврыг гаргаж, мөрдөж ажиллах нь үр дүнтэй гэж үзэж байна.

НООЛУУРЫН УРАМШУУЛАЛ

УИХ-ын 2020 оны “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” 32-р тогтоолд “малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20,000 төгрөгийн урамшууллыг Малын генетик нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд бүрд олгох”-оор тусгасан байна.

Мөн “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 167-р тогтоол гарсан бөгөөд уг тогтоолын 4-д Малчдын орлогыг нэмэгдүүлэх болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор Монгол Улсын 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, ноолуурын хэмжээг “Монгол ямааны үүлдэр, омог. Ерөнхий шаардлага” (MNS 0550:2011) стандартаар тооцож, нэг кг тутамд 20,000 төгрөгийн урамшууллыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгасан байна.

Эдгээр тогтоолыг хэрэгжүүлэхдээ заасан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.2-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны төсөвт холбогдох зохицуулалт хийх замаар санхүүжүүлэхийг Засгийн газрын уг тогтоолоор Сангийн сайдад зөвшөөрчээ.

Ийнхүү ноолуурын урамшуулалд зориулан иргэдэд төрөөс олгох мөнгөн шилжүүлэг хэлбэрээр 2020 онд 174.9 тэрбум төгрөгийг, ноолуур бэлтгэлд зориулан ААН-үүд зээлийн хүүгийн

хөнгөлөлт хэлбэрээр 5.1 тэрбум төгрөгийг, нийт 180.0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Малчдын хувьд ноолуур нь үнэ цэнтэй, зах зээлийн механизмын дагуу өрсөлдөх чадвар бүхий түүхий эд тул цаашид төрөөс хөндлөнгөөс оролцож, төсвийн зардал гаргах шаардлагагүй юм.


4.4. ХАА-Н ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛЛЫН ТАЛААРХ АНКЕТ СУДАЛГАА

Хөдөө аж ахуйн урамшуулал нь малчид, тариаланчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, гарц, чанарт гарч байгаа өөрчлөлт, амьжиргааны түвшин, өрхийн орлого, ажил эрхлэлтэд ямар нөлөө үзүүлсэн талаарх малчид, тариаланчдын санал, бодлыг сонсож, үнэлэлт өгөхөд энэхүү анкет судалгааны зорилго чиглэгдсэн.

ХАА-н татаас, дэмжлэгийн үр нөлөө, түүний ашиг шим хүртэгчдийн үнэлгээг илрүүлэхийн тулд орон нутагт малчид, тариаланчдаас санамсаргүй түүврийн аргаар анкетын судалгаа авсан болно.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд Булган, Төв, Дархан-Уул, Орхон болон Сэлэнгэ аймгийн 14 сумын малчид, тариаланчид, төрийн албан хаагчид хамрагдлаа.

Зураг 13: САНАМСАРГҮЙ ТҮҮВРИЙН СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ



Судалгааны арга зүй. Булган, Төв, Дархан-Уул, Орхон болон Сэлэнгэ аймгийн нийт 14 сумын 200 малчин, 100 тариаланч буюу нийт судалгаанд оролцогч 300 хүнийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон анкетын судалгаа (хавсралт 1), уулзалт, фокус ярилцлага авч, SPSS өгөгдлийн программ ашиглан боловсруулж, судалгааны үр дүнг гаргалаа. Улсын төсвийн дэмжлэг, урамшууллын хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ дараах хүрээг хамарсан болно. Үүнд:

- Малчдад олгосон ноос, ноолуур, арьс шир, мах болон сүүнд олгож байгаа урамшууллын үр нөлөө;
- Тариаланчдад олгосон улаан буудайн урамшуулал үр нөлөө;

Судалгаанд урамшуулалд хамрагдаагүй мал бүхий иргэд, улаан буудайн тариалалт эрхэлдэг жижиг аж ахуйн нэгж, иргэд, төмс, хүнсний ногоо эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, иргэдийг мөн хамруулсан болно.

Оролцогчдын байдал: Судалгаанд хамрагдсан 300 оролцогчид, эдгээр аймаг, сумдын Засаг дарга, хөдөө аж ахуйн газрын дарга, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын бодлогын хэрэгжилт, зохион байгуулалт, тулгарч буй асуудлын хүрээнд ярилцлага хийсэн.

Хүснэгт 25. Судалгаанд оролцогчдын байдал

Аймаг	Сумын нэр	Хамрагдсан хүний тоо			Эзлэх хувь		
		Нийт	Малчин	Тариаланч	Нийт	Малчин	Тариаланч
ТӨВ	Аргалант	29	19	10	10	10	10
	Баянхангай	31	23	8	10	12	8
	Жаргалант	27	16	11	9	8	11
БУЛГАН	Булган	20	17	3	7	9	3
	Бугат	10	8	2	3	4	2
	Бүрэгхангай	38	28	10	13	14	10
СЭЛЭНГЭ	Сүхбаатар	7	7	0	2	4	0
	Баруунбүрэн	42	27	15	14	14	15
	Мандал	27	14	13	9	7	13
ДАРХАН	Хонгор	27	19	8	9	10	8
	Орхон	22	15	7	7	8	7
ОРХОН	Баян-өндөр	2	0	2	1	0	2
	Жаргалант	18	7	11	6	4	11
Нийт		300	200	100	100	100	100

Эх сурвалж: Анкет судалгаа

Оролцогчдын урамшуулалд хамрагдсан байдал: Судалгаанд нийт 200 малчин хамрагдсанаас МАА-н бүтээгдэхүүний урамшуулалд 99 нь хамрагдсан, 101 нь ямар нэгэн урамшуулалд хамрагдаагүй байна. Мөн судалгаанд хамрагдсан 100 тариаланчаас улаан буудайн урамшуулалд 14 нь хамрагдсан, 86 нь хамрагдаагүй байна. Хамрагдаж чадаагүй тариаланчдын 54.8 хувь нь төмс, 16.1 хувь нь хүнсний ногоо, 14.5 хувь нь малын ногоон тэжээл тариалдаг бол 14.5 хувь нь улаан буудайн тариалан эрхлэгч өрх, аж ахуйн нэгж байна.

Хүснэгт 26. Судалгаанд оролцогчдын урамшуулалд хамрагдсан байдал

Үзүүлэлт		Аймаг					Нийт	Эзлэх хувь
		Төв	Булган	Орхон	Дархан	Сэлэнгэ		
Төрөл	Малчин	58	53	7	34	48	200	67
	Тариаланч	29	15	13	15	28	100	33
Малчид	Хамрагдсан	32	25	3	21	18	99	49.5
	Хамрагдаагүй	26	28	4	13	30	101	50.5
Тариаланчид	Хамрагдсан	2	3	2	2	5	14	14.0
	Хамрагдаагүй	27	12	11	13	23	86	86.0

Эх сурвалж: Анкет судалгаа


Урамшуулалд хамрагдаж чадаагүй шалтгаан: ХАА-н дэмжлэг, урамшуулалд хамрагдаж чадаагүй шалтгаан нь юу вэ? гэсэн асуултад малчид болон тариаланчид дараах байдлаар хариулсан байна. Үүнээс: 42 хувь нь дэмжлэг, урамшууллын талаарх мэдээлэл сул, хангалтгүй учраас мэдээллээс хоцордог; 27 хувь нь цөөн тооны малтай, талбайн хэмжээ бага эсвэл түрээсийн талбайтай учраас хамрагдаж чаддаггүй, 16.0 хувь нь олон тооны бичиг баримт шаарддаг, шат дамжлаг болон ажиллагаа; 11.6 хувь нь бичиг баримт, мэдээллийн зөрүүтэй байдлаас шалтгаалан урамшууллаа авч чадаагүй, 5 хувь нь урамшуулалд хамрагдах хугацаанд бичиг баримтаа бүрдүүлж өгч чадаагүй гэсэн байна.

Өөрөөр хэлбэл, урамшуулалд хамрагдаагүй хэсгийн дийлэнх нь (85 хувь) мэдээлэл олж авч чадаагүй, шат дамжлага ихтэй, эсвэл цөөн малтай, эсвэл бага хэмжээний талбайтай жижиг аж ахуй эрхэлдэг шалтгаанаар урамшуулалд хамрагдаж чадаагүй байна.


Малчдаас авсан анкетан судалгааны үр дүн

Зураг 14. МАЛЫН ТОО БА ОРЛОГЫН ТҮВШИН

Судалгаанд оролцогчдын малын тоо ба урамшуулалд хамрагдсан байдал



Судалгаанд хамрагдсан малчдын орлогын түвшин



Эх сурвалж: Анкет судалгаа

Малын тооны бүлэглэлээр авч үзэхэд урамшуулалд хамрагдсан оролцогчдын 58.3 хувь нь 101-500 толгой мал, 17.7 хувь нь 501 дээш толгой малтай байна. Харин урамшуулалд хамрагдаагүй оролцогчдын 75.3 хувь нь 100 хүртэлх толгой малтай, 11.7 хувь нь 101-200 толгой малтай байна.

Урамшуулалд хамрагдсан оролцогчдын 52.8 хувь нь 6 сая төгрөгөөс бага, 41.6 хувь нь 6-15 сая төгрөгийн хооронд, 5.6 хувь нь 15 сая төгрөгөөс дээш жилийн орлоготой гэсэн хариулт өгсөн байна. Урамшуулалд хамрагдаагүй оролцогчдын хувьд 77.5 хувь нь 6 сая төгрөг хүртэл, 21.5 хувь нь 6-15 сая төгрөг, 1.3 хувь нь 15 сая төгрөгөөс дээш орлоготой байна.


Урамшуулалд хамрагдаагүй оролцогчидтой харьцуулахад хамрагдсан малчид, мал бүхий иргэдийн хувьд харьцангуй олон тооны малтай төдийгүй орлогын түвшин өндөр байгаа бол харьцангуй цөөн малтай, орлого багатай малчид урамшуулалд хамрагдах нь бага байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл урамшуулал нь малчдын орлогын ялгааг багасгахад сайн нөлөө үзүүлэхгүй байх хандлага харагдаж байна.

Малчдын малын тооны өөрчлөлт, малын үүлдэр угсаагаа сайжруулахад урамшууллын нөлөө бий эсэхэд урамшуулал авсан оролцогчдын 45.3 хувь мэдэхгүй, 18.1 хувь нь нөлөөлөөгүй, 30.8 хувь нөлөөлсөн гэж хариулсан байна.

Зураг 15. МАЛЧДАД ҮЗҮҮЛСЭН УРАМШУУЛЛЫН ҮР НӨЛӨӨ

Судалгаанд оролцогчдын малын тоо ба урамшуулалд хамрагдсан байдал


Судалгаанд хамрагдсан малчдын орлогын түвшин




Судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь ХАА-н урамшуулал нь өрхийн амьжиргааг сайжруулахад нөлөөлж чадсан, үлдсэн 50 хувь нь нөлөөлөөгүй, мэдэхгүй байна гэж хариулсан байна. Бүлгийн ярилцлагын үеэр Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган болон Төв аймгийн малчид, мал бүхий иргэд эрчимжсэн мал аж ахуй, эсвэл ашиг шим, гарц сайтай үүлдэр угсааг сайжруулах тал дээр илүү сонирхолтой байгаа талаар ихэнх оролцогчид илэрхийлж байв.

Зураг 16. МАЛЧДЫН УРАМШУУЛЛЫН ТАЛААРХ САНАЛ, БОДОЛ

ХАА-н дэмжлэг, урамшууллын бодлогыг сайжруулах хэрэгтэй юу?



Дэмжлэг, урамшуулалын санхүүжилтийг хэрхэн өөрчилбөл илүү үр дүнтэй, үр ашигтай байх вэ?




Эх сурвалж: Анкет судалгаа

Малчдаас ХАА-н дэмжлэг, урамшууллын бодлогыг сайжруулах шаардлага байгаа эсэхийг асуухад урамшуулалд хамрагдсан болон хамрагдаагүй малчдын 80 орчим хувь нь сайжруулах нь маш зөв, зөв гэж хариулсан байна. Түүнчлэн бага хүүтэй хөнгөлөлттэй зээлд хамрагдах, техник технологийн дэмжлэг авах малчид багагүй хувь эзэлж байгаа нь дээрх зургаар үзүүлсэн хариултаас харж болно.

Тариаланчдаас авсан анкетын судалгааны үр дүн

Зураг 17. ТАРИАЛАНЧДЫН АЖЛЫН ТУРШЛАГА, ӨРХИЙН ОРЛОГО БА УРАМШУУЛАЛ



Урамшуулалд хамрагдсан газар тариалан эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжийн дийлэнх нь 2010 оноос өмнө байгуулагдсан, үүний дотор 50.0 хувь нь 1990-2000 онд, үлдсэн хувь нь 2001-2010 онд байгуулагдсан байна. Харин урамшуулалд хамрагдаагүй тариаланчдын хувьд 57 хувь нь 2010 оноос өмнө, 13.8 хувь нь 2011-2015 онд, 29.2 хувь нь 2016-2020 онд тус тус тариалан эрхэлж эхэлжээ.

Өнгөрсөн хугацаанд ажиллагсдын тоонд төдийлөн өөрчлөлт гараагүй байна. Улаан буудайн урамшуулалд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн хувьд судалгаанд оролцогчдын 76.9 хувь нь 10 хүртэлх, 23.1 хувь нь 11-20 хүртэлх байнгын ажлын байраар хангаж байна. Харин урамшуулалд хамрагдаагүй оролцогчдын 73.5 хувь нь 10 хүртэлх, 11.8 хувь нь 11-20 хүртэлх, 14.7 хувь нь 21 ба түүнээс дээш тооны ажиллагсадтай байна.

Улаан буудайн урамшуулалд хамрагдсан иргэдийн 61.5 хувь нь жилд 51 сая төгрөг ба түүнээс дээш, 15.4 хувь нь 21-50 сая төгрөгийн орлого олдог байна. Харин урамшуулалд хамрагдаагүй иргэд, аж ахуйн нэгжийн хувьд 58.2 хувь нь 1-5 сая, 36.4 хувь нь 6-10 сая төгрөг, 5.5 хувь нь 16-20 сая, 21.8 хувь нь 21-50 сая төгрөгийн борлуулалтын орлоготой гэсэн хариулт өгсөн байна. Урамшуулалд хамрагдаагүй оролцогчидтой харьцуулахад урамшуулалд хамрагдсан тариаланчдын дийлэнх нь харьцангуй өндөр орлоготой байна.

Урамшуулалд хамрагдсан бүх тариаланчид нь 101 га-аас дээш, ялангуяа 7 хувь нь 800 га-аас дээш тариалангийн талбайтай байна. Урамшуулалд хамрагдсан оролцогчдын 57.1 хувь нь өнгөрсөн хугацаанд талбайгаа нэмэгдүүлж чадсан бол 42.9 хувь нь хэвээр байна.

Урамшуулалд хамрагдсан оролцогчдын 35.8 хувь нь 1,001-5,000 тн, 28.5 хувь нь 5,001-10,000 тн, 35.7 хувь нь 10,000 ба түүнээс дээш тн. улаан буудайн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн

байна. Урамшуулалд хамрагдаагүй иргэд, аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь багахан талбайд төмс, хүнсний ногоо тариалдаг иргэд, аж ахуйн нэгжүүд байгаа бөгөөд дийлэнх нь 5.0 тн ба түүнээс бага хэмжээний өрхийн хэрэгцээний ургац хураасан байна.

Тариаланчдад үзүүлсэн урамшууллын нөлөөлөл. Урамшуулалд хамрагдсан тариалан эрхлэгчдээс “Урамшуулал олгосноор танай бизнесийн орлогод өөрчлөлт гарсан уу?” гэсэн асуултад 66.6 хувь нь тодорхой хэмжээнд нөлөөлсөн, 33.4 хувь нь нөлөөлөөгүй, мэдэхгүй байна гэж хариулжээ. Улаан буудай тариалдаг судалгаанд оролцогчдын 92.3 хувь нь га талбайгаас 20 хүртэл, 7.7 хувь нь 20-50 центр улаан буудай хурааж авдаг гэжээ. Судалгаанд оролцогчдын 42.2 хувь нь урамшуулал авснаар бүтээмж, гарцад нөлөөлж чадсан, харин 57.8 хувь нь чадаагүй, нөлөөлөөгүй гэсэн хариулт өгсөн байна.

Бүтээгдэхүүний чанарт нөлөөлсөн байдал. Судалгааны дүнгээс харахад 58.3 хувь нь төсвийн урамшуулал нь чанарт зохих хэмжээгээр нөлөөлсөн, 41.7 хувь нь нөлөөлж чадаагүй гэсэн байна.

ХАА-Н УРАМШУУЛЛЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААРХ СУДАЛГААНД ХАМРАГДАГСДЫН САНАЛ

ХАА-н урамшууллын зохион байгуулалт, хэлбэрийг хэрхэн сайжруулах талаар судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь бордоо, түлш хэлбэрээр, 33.3 хувь нь техник, тоног төхөөрөмж хэлбэрээр, 25.0 хувь нь дундын техник, тоног төхөөрөмжийн түрээсийн төвтэй болох, 16.7 хувь нь мөнгөн урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх нь зүйтэй гэсэн хариулт өгсөн байна. Улаан буудайн тариалан эрхэлдэг зарим томоохон аж ахуйн нэгжүүд нь мөнгөн урамшууллыг зогсоож, урт хугацааны бага хүүтэй зээлд хамруулах, зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэсэн саналтай байна. Урамшуулалд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн 50 орчим хувь нь автоматжуулсан агуулахтай бөөний төв байгуулах, 8.3 хувь нь урт хугацааны зээлд хамруулах хэрэгтэй гэсэн хариулт өгсөн байна.

Малчид, мал бүхий иргэд “ХАА-н дэмжлэг, урамшууллын бодлогыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай юу?” гэсэн асуултад 82 хувь нь үргэлжлүүлэх нь зөв гэж хариулсан бөгөөд хэрэгжүүлэх арга зам, механизмаа сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Урамшуулал олгож буй зохион байгуулалтын хувьд ХАА-н урамшууллын бодлогыг хэрхэн сайжруулах талаар судалгаанд оролцогчдоос асуухад тэдний 45 хувь нь цахим хэлбэрт шилжүүлж урамшуулал олгох процессыг хялбаршуулах хэрэгтэй гэжээ. Мөн тэдний 18.3 хувь нь мөнгөн хэлбэрээр, 16.8 хувь нь мөнгөн бус хэлбэрээр олгодог байх нь зүйтэй, үлдсэн хувь нь зохион байгуулалтыг сайжруулах, жинхэнэ хоршоо байгуулж, хоршоогоор дамжуулан урамшууллыг олгодог байх зэрэг хариулт өгсөн байна.

Нийт судалгаанд хамрагдагсдын 26.7 хувь нь зөвхөн үржлийн мал, бордоо, техник, тоног төхөөрөмжийн хөнгөлөлтөд хамруулах, 25.0 хувь нь урт хугацааны 3 хувийн хүүтэй зээлд хамруулах арга хэмжээ авах, 20.0 хувь нь өнөөгийн хэлбэрээр үргэлжлүүлэн олгох, 16.1 хувь

нь урамшууллын хэмжээг нэмэгдүүлэх, 9.4 хувь нь тухайн бүрд газар дээр шууд олгодог байх тогтолцоотой болох, 2.8 хувь нь урамшууллын бодлого хэрэггүй, зогсоох хэрэгтэй гэжээ.

4.5. РЕГРЕССИЙН ШИНЖИЛГЭЭ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Энэхүү шинжилгээний зорилго нь тухайн хөдөө аж ахуйн түүхий эдийн бэлтгэл, үйлдвэрлэлд урамшуулал, үйлдвэрлэлийн бусад хүчин зүйлсийн нөлөөллийг шинжлэхэд оршино. ХАА-н салбарын хамгийн өндөр урамшуулал олгосон буюу нийт мөнгөн урамшууллын 66.1 хувийг эзэлж буй ноос, арьс шир, үр тариа гэсэн 3 түүхий эдийг сонгон авсан.

Олон хувьсагчийн хүчин зүйлсийн регрессийн шинжилгээ хийхэд хангалттай урт хугацааны статистикийн тоон мэдээллийг шаарддаг учраас ноос, арьс, шир, улаан буудай гэсэн 3 түүхий эд бэлтгэлийн регрессийн шинжилгээг хийв.

Энэ үйлдвэрлэлийн функцэд бодлогын сонирхсон хувьсагчдыг нэмж, тооцоолол хийх боломжтой байдаг. Шугаман тэгшитгэлийн коэффициентийг тооцоход хялбар Кобб Дугласын үйлдвэрлэлийн функцийг¹¹ логаритм хэлбэрийг сонгон ашиглав. Үйлдвэрлэлийн функцийг тэгшитгэлийг доорх томъёогоор илэрхийлэв. Үүнд:

$$\text{Log } Y_{tij} = \alpha + \beta_1 i * \text{Log } X_{1ti} + \beta_2 i * \text{Log } X_{2ti} + \beta_3 i * \text{Log } X_{3ti} + \dots + \beta_{ni} * \text{Log } X_{nti} + U_{ti} \quad (1)$$

Тэмдэглэгээ:

Y_{tij} = t жилд i аймгийн j нэр төрлийн түүхий эдийн үйлдвэрлэлийн хэмжээ буюу хамаарлын хувьсагч

X_{1tij} = t жилд i аймгийн j нэр төрлийн түүхий эдийн үйлдвэрлэлд нөлөөлөх хүчин зүйл X1 буюу үл хамаарах хувьсагч X1

X_{2tij} = t жилд i аймгийн j нэр төрлийн түүхий эдийн үйлдвэрлэлд нөлөөлөх хүчин зүйл X2 буюу үл хамаарах хувьсагч X2

X_{3tij} = t жилд i аймгийн j нэр төрлийн түүхий эдийн үйлдвэрлэлд нөлөөлөх хүчин зүйл X3 буюу үл хамаарах хувьсагч X3

X_{ntij} = t жилд i аймгийн j нэр төрлийн түүхий эдийн үйлдвэрлэлд нөлөөлөх хүчин зүйл XN буюу үл хамаарах хувьсагч XN

U_{tij} = t жилд i аймгийн j нэр төрлийн түүхий эдийн үйлдвэрлэлд нөлөөлөх тооцоогүй бусад хүчин зүйлийн нөлөөллийг харуулсан үлдэгдэл

β_{1j}, β_{2j}, β_{3i}, ..., β_{nj} - тооцооны коэффициент буюу j нэр төрлийн түүхий эдийн үйлдвэрлэлийн хүчин зүйл бүрийн (1 ÷ N) мэдрэмж

Log = логаритм тэмдэглэгээ

¹¹ Кнут Юикселл нь Кобб Дуглас загварыг хөгжүүлж, 1928 онд Чарлес Кобб, Паул Дуглас нар статистик тест хийсэн. Кобб-Дугласын үйлдвэрлэлийн функцэд ажиллах хүч, ус, техникийн чадвар, бордоо гэх мэт олон эхоже болон эндо хүчин зүйлээс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хамаарна гэж үздэг. (Nastis et al., 2012)

2010-2020 онд нийт аймаг, нийслэлийн бэлтгэсэн түүхийн эдийн мэдээллийг авч ашиглав. Өгөгдөл мэдээллийг түүхий эдийн нэр төрөл тус бүрээр Хавсралт 1-т харуулав.

Дээрх Кобб-Дугласын үйлдвэрлэлийн функцийн эмпирик загварыг ашиглан сонгосон түүхий эдийн тус бүрийн хувьд регрессийн шинжилгээ хийв.

Шинжилгээний дэлгэрэнгүй үр дүнг Хавсралт 3-т өгүүлэв. Регрессийн шинжилгээний нэгтгэсэн дүнг хүснэгт 27-д харуулав.

Хүснэгт 27. Регрессийн шинжилгээний нэгтгэсэн дүн

Түүхий эдийн нэр төрөл	Урамшууллын нөлөөллийн коэффициент
Ноос	0.224
Арьс шир	0.149
Улаан буудай	0.565

Регрессийн шинжилгээнээс үзэхэд түүхий эд тус бүрийн бэлтгэл, үйлдвэрлэлийн хэмжээнд урамшуулал эерэг нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал, үйлдвэрлэлийн бусад хүчин зүйлийг тогтмол байлгаад түүхий эд тус бүрийн урамшууллыг 10 хувь нэмэгдүүлэхэд улаан буудай үйлдвэрлэл 5.7 хувь, ноос бэлтгэн нийлүүлэлт 2.2 хувь, арьс шир бэлтгэн нийлүүлэлт 1.5 хувь тус тус өсөхөөр байна. Сонгосон түүхий эдийн үйлдвэрлэлийн регрессийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд хөдөө аж ахуйн түүхийн эд бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэлд урамшуулал эерэг нөлөө үзүүлж байна. Гэвч үйлдвэрлэлийн бусад хүчин зүйлстэй харьцуулахад урамшуулал харьцангуй бага нөлөө үзүүлж байна. Өөрөөр хэлбэл, урамшууллын үр ашиг бага байна.

4.6. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ҮЗҮҮЛСЭН ДЭМЖЛЭГИЙН ТООЦОО

ЭЗХАХБ-ын боловсруулан ашигладаг хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн тооцоо (Producer support estimate)-ны хялбарчилсан аргачлалыг ашиглан манай улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд үзүүлж буй дэмжлэгийн тооцоог хийв. 2014 онд Дэлхийн Банк ЭЗХАХБ-ын аргачлалд тохируулга хийх замаар манай улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд үзүүлж буй дэмжлэгийн тооцоог онд анх удаа хийсэн байна.¹² Хялбарчилсан аргачлалыг ашиглан тооцоог шинэчилсэнээр харьцуулах боломж олгоно гэж үзлээ.

ЭЗХАХБ-ын аргачлалын зааврын дагуу хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгт үйлдвэрлэлийн орц, гарцад суурилсан шууд болон шууд бус бүхий л төлбөрийг багтаадаг байна. Өмнөх бүлэгт дурдсанчлан ноос, ноолуур, арьс шир болон улаан буудайд олгож буй урамшуулал нь гарцад суурилсан дэмжлэг байна.

Үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн тооцоонд зах зээлийн үнийн дэмжлэг (Market Price Support¹³) -ийг тооцдог. Түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэлийн хэмжээг түүхий эдийн дотоодын болон импортын (эсхүл хилийн) үнийн зөрүүгээр үржүүлэн зах зээлийн үнийн дэмжлэгийг тооцно. Энэ нь хэрэглэгч (гадаад хэрэглэгчдийг хамруулан), татвар төлөгчдөөс хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчдэд олгож буй шилжүүлгийг илэрхийлнэ.

¹² Kisan Gunjal and Chares Annor-Frempong, World Bank, Review, Estimation and Analysis of Agricultural subsidies in Mongolia Mar 30, 2014

¹³ OECD-ийн "PSE Manual" гарын авлагын 4 дүгээр бүлэгт тодорхой тусгасан.

¹⁴ WB 2014

Импортын тариф, бусад худалдааны хязгаарлалт, экспортын урамшуулал зэрэг засгийн газрын бодлогын интервенцийн үед зах зээлийн үнийн дэмжлэгийг тооцох нь зүйтэй юм. Эдгээр нь зах зээлийн үнэд нөлөөлдөг билээ.

Манай Улсын гаалийн татварын хэмжээ бага тул бодлогын интервенцийн улмаас зах зээлийн үнийн гажуудал гарна гэсэн хэрэг юм. Гэсэн ч бодлогын интервенцийн зэрэгцээ зах зээлийн бодит үнэ болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн борлуулалтын үнэ хооронд зөрүү байх зах зээлийн уламжлалт бүтэц, зах зээлийн нөхцөл байдал, үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааны үр дүн зэрэг хүчин зүйлээс хамаарч болдог. Манай улсын зарим түүхий эдийн зах зээлийн үнийн зөрүү гарснаар илэрнэ.

Онолын үүднээс үзэхэд манай улсын зах зээлийн үнийн зөрүү сөрөг байх нь дараах гурван шалтгаанаас үүдэлтэй байх талтай¹⁴. Үүнд:

1. Дотоодын түүхий эдийн үнэ бууруулах бодлого (түүхий эдийн үнэ)
2. Түүхий эдийн зах зээлийн шударга бус өрсөлдөөн
3. Олон улсын үнийн огцом өөрчлөлт (ялангуяа өсөлт) дотоодын зах зээл, борлуулалтын үнэд бага нөлөөлөх шилжих.

Сүүлийн жилүүдэд манай улсын баримталж ирсэн бодлого нь дотоодын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, хэрэглэгчдийн хэрэгцээний улаан буудай, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн үйлдвэрлэлийг дэмжих явдал байсан. Үүнээс гадна зах зээлийн үнийн зөрүү сөрөг байх боломжит өөр шалтгаан бол манай улсын түүхий эдийн зах зээлийн өрсөлдөөн бага, гадаад зах зээлийн өөрчлөлтөд дотоодын зах зээл хурдан зохицох чадваргүй явдал юм.

Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгийн тооцооны хялбарчилсан аргачлалын дагуу хийсэн тооцоог дор тайлбарлав. Үүнд:

1. Сонгосон түүхий эд тус бүрийн үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгийн хэмжээг тооцов.

Үүнд:

A. Ноос

Хэмжих нэгж -ХН

Хүснэгт 28. Ноосны зах зээлийн үнийн дэмжлэгийн тооцоо

Үзүүлэлт	ХН	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
I. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ	тонн	17,117.7	17,266.2	18,586.9	21,429.2	23,618.7	27,220.8	29,134.5	32,520.6	35,060.5	35,867.1	37,803.7
II. Үйлдвэрлэгчийн үнэ	төг\кг	609.2	815.7	708.5	708.5	610.5	602.2	647.5	1814.5	3279.0	813.3	1043.4
III. Үйлдвэрлэлийн үнийн дүн (үйлдвэрлэгчийн үнээр)	сая төг	10,427.6	14,083.5	13,168.3	15,182.4	14,418.2	16,392.7	18,863.2	59,009.2	114,963.5	29,172.4	39,442.8
IV. Хэрэглээний тоо хэмжээ	тонн	16,585.0	10,457.0	15,200.0	19,500.0	20,000.0	19,100.0	18,700.0	21,700.0	21,000.0	17,000.0	13,200.0

V. Хэрэглээний үнэ (үйлдвэрлэгчийн үнээр)	төг\кг	609.2	815.7	708.5	708.5	610.5	602.2	647.5	1814.5	3279.0	813.3	1043.4
VI. Хэрэглээний үнийн дүн	сая төг	10,103.1	8,529.5	10,768.7	13,815.6	12,209.1	11,502.3	12,107.3	39,375.0	68,859.1	13,826.9	13,772.3
VII. Харьцуулах үнэ (үйлдвэрлэгчийн үнээр)	төг\кг	402.0	409.2	553.5	861.4	1,136.2	1,047.1	1,234.2	1,554.8	2,061.9	1,870.3	1,415.2
1. Хилийн үнэ (ФОБ)	ам.дол \тонн	1,010.5	1,087.0	1,279.6	1,315.2	1,406.3	1,206.7	1,281.5	1,390.3	1,782.4	1,510.8	1,159.8
2. Тээврийн зардал	төг\кг	142.1	142.1	142.1	142.1	142.1	142.1	142.1	142.1	142.1	142.1	216.6
3. Чанарын тохируулга	хувь	0.4	0.4	0.4	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5
4. Албан ханш	төг\ ам.дол	1,346.0	1,268.0	1,359.0	1,526.0	1,818.0	1,971.0	2,148.0	2,441.0	2,473.0	2,664.0	2,814.0
VIII. Зах зээлийн үнийн зөрүү (II-VII)	төг\кг	207.2	406.4	154.9	-152.9	-525.8	-444.9	-586.8	259.7	1217.1	-1,056.9	-371.9
IX. Зах зээлийн шилжүүлэг	сая төг	3,436.3	4,250.0	2,354.9	-2,982.5	-321.0	-8,498.0	-379.9	5,635.5	25,560.1	-17,968.1	-4908.8
1. Хэрэглэгчээс үйлдвэрлэгчид шилжүүлэг	сая төг	3,436.3	4,250.0	2,354.9	-2,982.5	0.0	0.0	0.0	5,635.5	25,560.1	0.0	0.0
2. Үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шилжүүлэг	сая төг	0.0	0.0	0.0	0.0	-321.0	-8,498.0	-379.9	0.0	0.0	-17,968.1	-4908.8
3. Хэрэглэгчийн бусад шилжүүлэг	сая төг											
X. Төсвийн шилжүүлэг	сая төг	110.4	2,767.4	524.7	955.4	4,837.3	4,817.6	6,026.8	2,810.1	17,113.7	7,076.0	-609.5
1. Үйлдвэрлэгчээс татвар төлөгчид шилжүүлэг	сая төг	110.4	2,767.4	524.7	0.0	0.0	0.0	0.0	2,810.1	17,113.7	0.0	0.0
2. Үйлдвэрлэгчийн бусад шилжүүлэг	сая төг	0.0	0.0	0.0	955.4	4,837.3	4,817.6	6,026.8			7,076.0	-609.5
3. Үнийн татвар (-)	сая төг	0.0	0.0	0.0								
XI. Зах зээлийн үнийн дэмжлэг (ЗЗҮД)	сая төг	3,546.7	7,017.5	2,879.6	0.0	-321.0	-8,498.0	-379.9	8,445.7	42,673.8	-17,968.1	-4,908.8

Ноосны зах зээлийн үнийн зөрүү сонирхол татаж байна. Жишээлбэл, 2013-2016 он болон 2019-2020 онд олон улсын зах зээл дээр ноосны үнэ өссөний улмаас дотоодын бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчид далд (implicit) татвар төлсөн. Энэ үед дотоодын зах зээлийн үнэ ноос бэлтгэн нийлүүлэгчд малчдын урамшуулал орсон үйлдвэрлэгчийн буюу борлуулалтын үнээс давсан байв.

Хүснэгт 29. Ноос бэлтгэн нийлүүлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн тооцоо

Үзүүлэлт	ХН	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Зах зээлийн үнийн дэмжлэг	сая төг	3,546.7	7,017.5	2,879.6	0.0	-321.0	-8,498.0	-379.9	8,445.7	42,673.8	-17,968.1	-4,908.8
Ноосны	сая төг	3,546.7	7,017.5	2,879.6	0.0	-321.0	-8,498.0	-379.9	8,445.7	42,673.8	-17,968.1	-4,908.8
Үйлдвэрлэлийн шууд төлбөр	сая төг	0.0	6,253.1	29,414.3	36,614.7	18,427.5	19,350.9	22,637.2	22,408.7	18,599.9	19,419.5	32,367.7
Ноосны урамшуулал	сая төг		6,253.1	29,414.3	36,614.7	18,427.5	19,350.9	22,637.2	22,408.7	18,599.9	19,419.5	32,367.7
Шууд бус төлбөр	сая төг	6,068.5	16,213.4	13,094.7	12,448.8	11,382.0	6,312.0	15,186.6	10,208.2	12,049.7	10,847.7	10,773.5
Мал аж ахуйн дэмжлэг	сая төг	3,496.6	7,580.3	3,794.5	5,637.7	5,452.1	1,067.5	1,371.6	766.9	767.2	1,557.1	1,415.8
Малын эрүүл мэндийн дэмжлэг	сая төг	2,571.9	8,633.1	9,300.3	6,811.1	5,929.9	5,244.5	13,815.0	9,441.3	11,282.4	9,290.6	9,357.7
Ноосны үйлдвэрлэлийн үнийн дүн	сая төг	10,427.6	14,083.5	13,168.3	15,182.4	14,418.2	16,392.7	18,863.2	59,009.2	114,963.5	29,172.4	39,442.8
Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэг (ҮҮД)	сая төг	9,615.2	29,483.9	45,388.6	49,063.4	29,488.5	17,164.9	37,443.8	41,062.6	73,323.3	12,299.1	38,232.4
Нийт борлуулалтын орлого	сая төг	16,496.1	36,550.0	55,677.2	64,245.8	44,227.7	42,055.6	56,686.9	91,626.1	145,613.0	59,439.6	82,584.0
Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгийн эзлэх хувь	сая төг	58.3%	80.7%	81.5%	76.4%	66.7%	40.8%	66.1%	44.8%	50.4%	20.7%	46.3%

2010-2020 онд ноос бэлтгэн нийлүүлэгч малчдад үзүүлсэн дэмжлэгийн тооцоогоор ноос бэлтгэн нийлүүлэгч малчдад үзүүлсэн дэмжлэг тэдний борлуулалтын жилийн орлогын дунджаар 57.5 хувьтай тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, тэдний борлуулалтын жилийн орлогын 1 төгрөг бүрийн 57.5 мөнгийг бодлогын дэмжлэг бүрдүүлсэн байна.

б. Арьс шир

Хүснэгт 30. Арьс шир бэлтгэн нийлүүлэгч малчдын зах зээлийн үнийн дэмжлэг

Үзүүлэлт	ХН	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
I. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ	Тонн	11,299.0	8,743.8	8,766.5	10,894.5	10,217.9	15,192.9	14001.2	14523.4	19290.6	19555.8	27119.0
II. Үйлдвэрлэгчийн үнэ	төг\кг	5.3	10.8	12.3	9.8	7.6	4.7	2.6	4.2	3.5	1.9	1.9
III. Үйлдвэрлэлийн үнийн дүн (үйлдвэрлэгчийн үнээр)	сая төг	59,954.7	94,536.4	107,758.9	106,505.5	77,436.8	70,849.0	36,923.4	60,343.4	67,960.6	37,514.2	50,550.5
IV. Хэрэглээний тоо хэмжээ	тонн	6300.0	6342.8	7,222.7	6,470.2	5,758.9	6475	5170	5359.1	5,207.7	7,469.2	8500
V. Хэрэглээний үнэ (үйлдвэрлэгчийн үнээр)	төг\кг	5.3	10.8	12.3	9.8	7.6	4.7	2.6	4.2	3.5	1.9	1.9
VI. Хэрэглээний үнийн дүн	сая төг	33,429.0	68,577.2	88,782.3	63,253.2	43,644.1	30,194.8	13,634.1	22,266.6	18,346.7	14,328.3	15,844.2
VII. Харьцуулах үнэ (үйлдвэрлэгчийн үнээр)	төг\кг	2.1	3.2	3.3	3.7	4.1	3.4	3.2	3.8	3.3	2.4	1.8
1. Хилийн үнэ (ФОБ)	ам.дол \тонн	5.9	8.9	8.4	8.4	7.6	6.1	5.2	5.3	4.7	3.3	2.5
2. Тээврийн зардал	төг\кг	497.2	497.2	497.2	497.2	497.2	497.2	497.2	497.2	497.2	497.2	497.2
3. Чанарын тохируулга	хувь	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3
4. Албан ханш	төг\ ам.дол	1,346.0	1,268.0	1,359.0	1,526.0	1,818.0	1,971.0	2,148.0	2,441.0	2,473.0	2,664.0	2,814.0
VIII. Зах зээлийн үнийн зөрүү (II-VII)	төг\кг	3.2	7.6	9.0	6.1	3.5	1.2	(0.5)	0.4	0.2	(0.5)	0.1
IX. Зах зээлийн шилжүүлэг	сая төг	20.1	48.0	65.2	39.2	20.1	7.9	(2.7)	2.1	1.1	(3.4)	0.6
1. Хэрэглэгчээс үйлдвэрлэгчид шилжүүлэг	сая төг	20.1	48.0	65.2	39.2	20.1	7.9	0.0	2.1	1.1	0.0	0.6
2. Үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шилжүүлэг	сая төг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-2.7	0.0	0.0	-3.4	0.0

3. Хэрэглэгчийн бусад шилжүүлэг	сая төг	0.0	0.0	0.0	0	0	0	0	0	0	0	0
X. Төсвийн шилжүүлэг	сая төг	16.0	18.2	13.9	26.8	15.6	10.6	-4.6	3.7	2.9	-5.5	1.2
1. Татвар төлөгчөөс үйлдвэрлэгчид шилжүүлэг	сая төг	16.0	18.2	13.9	26.8	15.6	10.6	0.0	3.7	2.9	0.0	1.2
2. Үйлдвэрлэгчийн бусад шилжүүлэг	сая төг							(4.57)			(5.52)	
XI. Зах зээлийн үнийн дэмжлэг	сая төг	36.1	66.2	79.1	66.1	35.7	18.5	-7.3	5.8	3.9	-8.9	1.8

2016, 2019 оноос бусад онд арьс шир нийлүүлэгч малчдын борлуулалтын үнэ хилийн үнээс давсан байна.

Хүснэгт 31. Арьс шир бэлтгэн нийлүүлэгч малчдад үзүүлсэн дэмжлэгийн тооцоо

Үзүүлэлт	ХН	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Зах зээлийн үнийн дэмжлэг	сая төг	36.1	66.2	79.1	66.1	35.7	18.5	- 7.3	5.8	3.9	- 8.9	1.8
Арьс ширний	сая төг	36.1	66.2	79.1	66.1	35.7	18.5	- 7.3	5.8	3.9	- 8.9	1.8
Үйлдвэрлэлийн шууд төлбөр	сая төг	-	-	-	2,711.7	8,179.3	9,500.8	12,713.0	14,611.5	9,462.2	9,913.0	-
Арьс ширний урамшуулал	сая төг				2,711.7	8,179.3	9,500.8	12,713.0	14,611.5	9,462.2	9,913.0	
Нийт үйлдвэрлэл	сая төг	59,954.7	94,536.4	107,758.9	106,505.5	77,436.8	70,849.0	36,923.4	60,343.4	67,960.6	37,514.2	50,550.5
Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэг	сая төг	36.1	66.2	79.1	2,777.8	8,215.0	9,519.3	12,705.8	14,617.3	9,466.1	9,904.1	1.8
Борлуулалтын орлого	сая төг	59,954.7	94,536.4	107,758.9	109,217.2	85,616.1	80,349.7	49,636.4	74,954.9	77,422.8	47,427.2	50,550.5
Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгийн эзлэх хувь	хувь	0.1%	0.1%	0.1%	2.5%	9.6%	11.8%	25.6%	19.5%	12.2%	20.9%	0.0%


2010-2020 онд арьс шир бэлтгэн нийлүүлэгч малчдын борлуулалтын жилийн орлогын дунджаар 9.3 хувьтай тэнцэх хэмжээний дэмжлэг үзүүлсэн байна.

с. Улаан буудай

Улаан буудайн хилийн болон дотоодын үнийг Зураг 16-д харуулав. ИТС байгууллага /trade-mar.org/-ын мэдээллийн сангаас авсан 2010-2020 онд манай улсад импортолсон улаан буудайн

ам. доллараар илэрхийлсэн үнийг албан дундаж ханшаар хөрвүүлэн тооцов. 2015 онд нэг тонн улаан буудайн импортын үнэ сүүлийн 10 жилд хамгийн өндөр 1,970.0 мянган төгрөг байсан байна. Улаан буудайн импортын дийлэнхийг ОХУ-аас импортолдог. 2012-2015 онд импортын үнэ өндөр байсан байна.

Зураг 18. УЛААН БУУДАЙН ИМПОРТЫН БОЛОН ДОТООДЫН ҮНЭ



Хөдөө аж ахуйг дэмжих сангаас тогтоож байгаа улаан буудайн жишиг үнэ /2015 оны үнийг эс тооцоолбол/ нь импортын улаан буудайн үнээс дунджаар 3-5 хувиар өндөр байна. 2012-2015 онд импортын улаан буудайн үнэ нь дотоодын үнээс өндөр байсан. Харин сүүлийн 5 жилд импортын улаан буудайн үнэ нь дотоодын зах зээлийн үнээс дунджаар 10-12 орчим хувиар бага байна.

Хүснэгт 32. Улаан буудай тариалагчдын зах зээлийн үнийн дэмжлэг

Үзүүлэлт	ХН	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
I. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ	тонн	345.5	435.9	465.3	368.5	488.3	203.9	467.1	231.4	436.1	411.4	406.1
II. Үйлдвэрлэгчийн үнэ	төг\кг	330.0	350.0	290.0	320.0	550.0	540.0	560.0	560.0	575.2	597.7	702.1
III. Үйлдвэрлэлийн үнийн дүн (үйлдвэрлэгчийн үнээр)	сая төг	114.0	152.6	134.9	117.9	268.6	110.1	261.5	129.6	250.9	245.9	285.1
IV. Хэрэглэний тоо хэмжээ	тонн	411.7	443.3	469.4	368.6	522.5	208.4	625.6	245.0	668.1	425.8	535.9

V. Хэрэглээний үнэ (үйлдвэрлэгчийн үнээр)	төг\кг	330.0	350.0	290.0	320.0	550.0	540.0	560.0	560.0	575.2	597.7	702.1
VI. Хэрэглээний үнийн дүн	сая төг	135.8	155.2	136.1	117.9	287.4	112.5	350.3	137.2	384.3	254.5	376.3
VII. Харьцуулах үнэ (үйлдвэрлэгчийн үнээр)	төг\кг	246.9	286.0	330.3	801.0	574.6	1,970.7	451.0	478.4	472.3	508.8	603.5
1. Хилийн үнэ (ФОБ)	ам.дол \тонн	182.0	226.0	243.0	525.0	316.0	1000.0	210.0	196.0	191.0	191.0	214.5
3. Албан ханш	төг\ ам.дол	1,356	1,266	1,359	1,526	1,818	1,971	2,148	2,441	2,473	2,664	2,814
VIII. Зах зээлийн үнийн зөрүү (II-VII)	төг\кг	83.1	64.0	(40.3)	(481.0)	(24.6)	(1,430.7)	109.0	81.6	102.9	88.9	98.6
IX. Зах зээлийн шилжүүлэг	сая төг	28.7	64.0	(40.3)	(481.0)	(24.6)	(1,430.7)	109.0	81.6	102.9	88.9	98.6
1. Хэрэглэгчээс үйлдвэрлэгчид шилжүүлэг	сая төг	28.7	27.9	0.0	0.0	0.0	0.0	50.9	18.9	44.9	36.6	40.0
2. Үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шилжүүлэг	сая төг			(18.9)	(177.3)	(12.8)	(298.1)	350.3	137.2	384.3	254.5	376.3
3. Хэрэглэгчийн бусад шилжүүлэг	сая төг											
X. Төсвийн шилжүүлэг	сая төг	0.0	0.0	0.0	0.0	-0.8	-6.4	17.3	1.1	23.9	1.3	12.8
1. Татвар төлөгчөөс хэрэглэгчид шилжүүлэг	сая төг	0.0	0.0	-0.2	0.0	-0.8	-6.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. Хэрэглэгчийн бусад шилжүүлэг	сая төг	5.5	0.5	0.0	0.0	0.0	0.0	17.3	1.1	23.9	1.3	12.8
XI. Зах зээлийн үнийн дэмжлэг	сая төг	28.7	64.0	-40.3	-481.1	-25.4	-1437.1	126.2	82.7	126.8	90.2	111.4

2010-2020 онд улаан буудайн зах зээлийн үнийн зөрүү, түүнд суурилан тооцсон зах зээлийн үнийн дэмжлэгийг Хүснэгт 33-д харуулав. 2012-2016 онд олон улсын зах зээл дээр улаан буудайн үнэ огцом өссөний улмаас улаан буудайн тариалан эрхлэгчид далд (implicit) татвар төлсөн.

Хүснэгт 33. Улаан буудай тариалагчдад үзүүлсэн дэмжлэгийн тооцоо

Үзүүлэлт	ХН	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Зах зээлийн үнийн дэмжлэг	сая төг	28.7	64.0	40.3	481.1	25.4	1,437.1	126.2	82.7	126.8	90.2	111.4
Үйлдвэрлэлийн шууд төлбөр	сая төг	10,906.4	14,471.2	27,829.5	25,320.7	24,727.1	5,591.5	14,962.4	7,873.1	12,930.3	22,420.8	22,717.1
Шууд бус төлбөр	сая төг	3,529.9	3,824.2	6,519.6	7,525.0	7,467.9	11,203.3	10,828.9	10,803.7	11,185.2	9,285.0	8,957.1
Бордоо	сая төг	-	16.4	51.1	39.7	21.0	125.8	319.8	372.1	162.1	149.5	81.4
Техник, трактор, тт зээл	сая төг	2,118.6	2,032.8	5,661.8	6,373.6	5,477.7	9,883.8	8,124.6	8,575.7	7,583.6	7,644.2	7,460.1
Үр	сая төг	438.7	367.7	175.0	173.3	728.4	0.3	938.9	498.7	1,759.3	326.6	900.6
Шатахуун	сая төг	802.0	1,080.5	289.4	638.7	860.4	786.0	919.4	887.0	1,186.5	856.3	380.2
Ургамал хамгаалал	сая төг	170.6	326.8	342.3	299.6	380.3	407.5	526.2	470.1	493.8	308.4	134.8
Үйлдвэрлэлийн үнийн дүн	сая төг	114,001.0	152,561.2	134,935.2	117,906.7	268,561.5	110,105.6	261,549.6	129,564.0	250,853.3	245,902.6	285,143.3
Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэг	сая төг	14,465.0	18,359.4	34,308.7	32,364.6	32,169.5	15,357.7	25,917.5	18,759.5	24,242.3	31,795.9	31,785.6
Борлуулалтын орлого	сая төг	128,437.3	170,856.6	169,284.3	150,752.4	300,756.4	126,900.3	287,340.8	148,240.8	274,968.8	277,608.4	31,6817.4
Үйлдвэрлэгчид үзүүлсэн дэмжлэгийн эзлэх хувь	%	11.3%	10.7%	20.3%	21.5%	10.7%	12.1%	9.0%	12.7%	8.8%	11.5%	10.0%

2010-2020 онд улаан буудай тариалагчдын борлуулалтын жилийн орлогын дунджаар 12.6 хувьтай тэнцэх хэмжээний үйлдвэрлэгчид үзүүлсэн (бодлогын) дэмжлэг үзүүлсэн байна. 2013 онд нийт борлуулалтын орлогод эзлэх үйлдвэрлэгчдэд үзүүлсэн дэмжлэгийн хэмжээ хамгийн өндөр 21.5 хувьд хүрсэн байв.

